Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай



# Миний Амьдрал дахь Нохой

БОРЛУУЛАЛТААРАА ТЭРГҮҮЛЭГЧ ШУВУУД МИНИЙ АМЬДРАЛД НОМЫН ЗОХИОЛЧ

Миний Амьдрал дахь Нохой
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Love Ocean

# Benny

*Бенни бол “надтай учирсан” анхны минь нохой. Мальти угсааных л даа.*

*Намайг үргэлж л харж хандаж байдаг ханилгаатай, эрх амьтан байгаа юм (налж шөргөөх дуртай). Жинхэнэ эрдэмтэн нохой. Босс, Альфа, Том Ах, Эрдэмтэн гээд олон хочтой.*

*К-9 Сонсогч хэмээх бэлтгэл сургуулийг төгссөн гэж байгаа. Сургуулийнхан нь түүний зан авир, сахилга батыг үнэхээр бишрч байсан сан. Төгсгөх үед нь би тэрнийг гэрээдээ аваачихаар сургууль дээр нь очсон юм. Багш нар нь түүнийг “хэвт” гэлээ. Тэр хэвтлээ. Хэдийгээр тэр маань над руу тэмүүлж байсан ч багшийнхаа зааврыг зөрчиж зүрхлэхгүй байгаа нь илт. Гэсэн ч тэр өөрийн эрхгүй над руу цэрэг шиг мөлхсөөр сөөм сөөмөөр дөхөж ирсэн сэн. Тэгснээ мөнөөх “хэвтээ”*

*байрлалтайгаа дэргэд минь ирэхэд сургуулийн багш болон тэнд байгсад уярсандаа нулимс унагаж билээ. “Бурхан минь! Бид тэрэнд ийм юм заагаагүй шүү дээ!”*

*Бенни бол маш өрөвчхөн, бас халамжтай нохой. Хэн нэгэн гунигтай байвал тэр дэргэд нь очиж, хөгжилтэй болтол нь хажууд нь байж тайтгаруулахыг хичээнэ. Манайхны нэг нь зориуд түүнээр тоглоом хийж, уйлсан болж аяглахад Бенни маань дэргэдээс нь огтхон ч холдолгүй, долоон үнсэж байсан сан. Хэрэв тэр явж байгаад гэмтэж бэртсэн шувуу ч юм уу, өөр амьтантай таарвал намайг очтол хажууд нь сахин хамгаалдаг. Бэртсэн амьтныг өөр хүн айлгахгүй л бол Бенни номхон тайван байдлаа ямагт хадгална.*

*Тэр ногоогоор хийсэн ясанд ухаангүй дуртай. Хэрэв өөрийг нь орхин гадуур гарах гэж байгааг минь мэдчихвэл мөнөөх дуртай ясаа ч үл тоон буланд шигдэн дуугаа хураана. Ор, буйдан гээд би л хаа байна, тийшээ сэмхэн гэтсээр дэргэд минь шигдчихсэн байдаг юм.*

*Намайг эзгүй байгаад гэртээ ирэх тоолон, эсвэл өөрийг нь өрөөндөө оруулах бүр тэр ор дэр, буйдан, шалавч гээд юу таарсан газраа эргэлдэн дунгуйрч баярласнаа илтгэдэг.*

*Бенни бол төрөл хувилсан хөөрхөн амьтан. Тэр намайг хайрлахаар заяагдсан, бяцхан нохойн дүрд энгүүнээр тоглож буй өндөр түвшний сүнс юм даа.*





Эхэнд би ганцаар – Бенни анхны,
цорын ганц нохой.




Ээж ээ, би энд байна!





Энэ гүүгл залуу хэн бэ?



Таван сартайдаа авахуулсан миний анхны зураг.



Цагаан цасан дундаас би ялгарч байна уу?
Азаар би улаан хантааз өмсч гарсан юм.
Бас нүд минь хар, хамар, ам минь ч хар л даа.

(Үл маань ч бас хар, гэхдээ энд юу гэж үзэгдэв гэж!)



Энэ бол Канадад авахуулсан зураг.
Би таван настай байсан юм.
Тий ти ти... хүйтэн байна шүү!

Аз болоход хэдэн сарын дараа бид тэндээс явсан даа.

Би Флоридад төрсөн.
Ийм цагаан цасыг би өмнө нь хэзээ ч үзээгүй!
Ээж бид хоёр цугтаа л байвал өвөл ч гэсэн нар ээдэг билээ.
Харин бид цэцэрлэгт хамт зугаалах үед, эсвэл далайн хөвөөнөө гэрээ сахин үлдэхэд нар хаашаа ч юм алга болчихдог.





Цас гээч нь үнэхээр хүмүүсийн ярьдаг шиг хүйтэн юм болов уу?
Юутай ч тэр их л зөөлхөн юм билээ. Малтахад их амархан.

Канад бол үнэхээр "саак" газар!
Яг л над шиг сэвсгэр.

жаргал жаргал жаргал жаргал жаргал жаргал жаргал жаргал жаргал жаргал жаргал жаргал жаргал жаргал

Бид ч **Жаргалтай** шүү!










Woa! Woa! Woa!

Энэ том ногоон цэцэрлэг минийх гэвэл яахав!



Би яагаа ч үгүй ээ. Зүгээр л жаахан шавар үхсан юм!



Тэгсэн ч гэсэн Тэр надад хайртай.

Би тэр савангийн дуурь"-т ёстой дургүй.



Би ийм биш ээ. Таатай юм алга!





Ингэх л ёстой юм байх даа??



Заа!...
Сайхан боллоо.
Учрыг нь одоо л оллоо.
Угаал хийлгэхээр сайхан болдог юм байна.







Ингээд цэвэрхэн боллоо!
(Дахиж гадуур гартлаа ийм байх юм шиү.)

Алий! Юм наалдчих шиг боллоо.
Болгоомжтойхон шиг аваарай!











Ингээд сууж
байхад ч
сайхан байна
шүү,
Ээж ээ!



Би ирээдүйдээ санаа зовохгүй ээ!
Тэр – миний ирээдүй.



Энд, энд...
Наана чинь жижигхээн өвс наалдчихаж!
Хөвсгөрхөн үсий минь хөнгөхөн шиг
цэвэрлээрэй!



Нуур ам минь заваартчихсан байхад яаж би инээх билээ!



Одоо гоё болчихлоо. Алив!
Зургаа дараарай!

Ха!
Ха!
Ха!





# Одоогоороо бай л даа







Ээж "одоогоороо л бай" гэсэн.



Гэвч би өнгөрсөн дурсамжаа арчиж чадахгүй!
Урьд нь байсан газар маань
тиймхэн л байж дээ.
Их л давчуу!
Их л аягүй!



Ногоон
цэцэрлэгээс
би юу олж
чадна гээч?



Хөөх!
Төмс байна!
Гэхдээ чанаж
болгосных нь дараа л
би иднэ.

Ээж ээ,
энд ямар их
ургамал
байна вэ!





Ёстой л
хаврын
амт
байна даа.
Юм бүхэн
шинэ!



Хар даа, ахиад л төмс!
Өөрсдийн гараар тарьсан
өег амттай төмс.



Их ч явлаа,
"их ч ажиллалаа" Эс хэллүү!





Та нар надад атаархаагүй биз?
Би зүгээр л ээжийнхээ албан
ажилд нь тусалж байгаа юм!








Бид ихэр юм шиг харагдаж байгаа даа!
Тэр хөршийн маань охин байгаа юм!
Ёстой хөөрхөн, бас цовоо!


Би бол Ээжийн хүү. Ингэхэд чи хэн билээ?


Белла! Би бол Белла.


Аан! Би бол Бен, Бенни!
Белла, танай хажуу айлын чинь охин!


Гүйцвэл намайг бариарай!


Яана гэнээ?


Заа за, Би бүр ядарчихлаа!


Бүүр ядарч орхилоо!

Хүүе! Би энд байна.

Хүүе! Би энд байна.








Энэ чинь өнгөлөн далдлалт уу, юув?



Энд нэг л бүүдгэрхэн байх чинь.



Айж тугших юмгүй, ямар ч сайхан юм.



Зураг авлаа шүү! Инээцгээгээрэй!



# Халамжинд хамтдаа...



Өөр нэг нохой
хүрээд ирлээ.
Хурган хав юм
болов уу?
Үгүй ээ, бижон!
"Бий-жоон".
Аа яа яа, лайтай!



Ахиад бас
нэг амьтан –
Эрлийз нохой!
Ээ, мөн аймаар!
"Халамжинд хамтдаа..."
Мэдэж байнаа, гэхдээ л...



Яахав, яахав!

Би жижигхэн гэдгээ мэднээ.

Би ердөө дөрөвхөн сартай байсан юм чинь.



Би юм идэх гээгүй ээ. Зүгээр л Таныг хайрлах гэсэн юм.



Чамд үзүүлээд өгнөө. Бие томтойгоороо түрий барих гээ юу?

Чи чадалтай юм бол би ухаантай.





Хөөе, энэ чинь минийх! Чинийх том шүү дээ, цаана чинь байна!



Тэхдээ бид цугтаа байх сайхан.



Тэр намайг
хайрласаар л!



Ха ха!

Бидний дунд хэн и орж ирлээ гэсэн

би энхэр нь! гэж чамд хэлээгүй юу!



Түүнийг бясалгаж байхад и гэсэн.



Хурган хав ч билүү, юу ч гэдэг билээ,
энэ ер нь янзын залуу шүү, аан!



Чи яагаад миний оронд "дээр" хэвтчихвээ!
(Тээр! Багтахгүй байгаа биз дээ!)



Наадах чинь чамд "жижигдэж байна"
гэж хэд хэлэх юм бэ?



Бид тун дажгүй харагдаж байгаа биз?
Тэр надад үргэлж наалдахыг нь яана.
Урьд насны үйлийн үр юм байлгүй дээ.



Надад тэр үргэлж л наалдаж байдаг
гэж хэлээгүй юу?
Тэр Ээжид минь татагдаад
зогсохгүй надад ч бас татагддаг юм!



Бид хэзээний л сайн найзууд!



Бурхан минь ээ!
Энэ бясалгал чинь хэзээ дуусах юм болоо?

Тэгвэл цэцэрлэгт орж, гүйж харайхгүй юу...



Бид хоёр яахав?

Харамсалтай нь чамайг
хэвтүүлэх өөр газар алга
даа, Лак минь!





Намайг тайван байлгаж үз!
Би "ногоон" ясаа мэрж байна.
Цаанаа байж бай!

Тэр хаа ч байлаа гэсэн, дотор нь диваажин байдаг!





Би ч гоёулах дуртай шуу.







Заримдаа ч…
тэр бүр хариугүй
жижигхэн амьтан
шиг санагддаг…

бас бүүр цөхөрчихсөн.



Хүн байна уу?
Хэн энэ дотроос
намайг гаргах юм болоо?





Энэ түнэр
харанхуйн
цаана юу
байна вэ?

Наадах чинь тогүй гэдэгт чи
итгэлтэй байна уу?



Тэнд юу байгаа бол, аан?

Явж юу байгааг нь харъя!

Санаа зоволтгүй ээ, ээж тогий
нь салгачихсан.





Сайн уу!
(Хөгжилтэй дуран минь.)





Үгүй ээ,
энэ хархүү
хаанаас
гараад
ирэв?

Хараач... ахиад нэг! Ээ, Бурхан минь гэж!





Сайхан байнаа, муу хэлэх юм алга!



## Харж байгаа биз?

Зөндөө олуулаа болчихсон байгааг.

Шаваарaлдсан ч гэсэн гоё байна өө.



Ингээд л эд нар "манай гэр"-ийн
сёорт хэвтээд байдаг юм.
Энд шавахаа боль гэж хэлээд буур ядчихлаа.



# Жуудu!

Намайг дагахаа боль
гэснийг минь мартчихаа юу?



Би унтмаар байна.
Унтах ч сайхан шүү!



Ээж гадуур явaa, гэхдээ удахгүй ирнээ, Бен.
Санаа зоволтгүй!



Ойрхон тусмаа сайн.





Тэд нар бууж ирээд надтай жаахан ч гэсэн тоглодоггүй юм байх даа!





Өөртэйгээ нэг л адилгүй
болчих чинь...
Үсий минь хаашаа
янзаар засчихваа!
Ээж үс чинь удахгүй
ургачихна гэсэн.
(Тэгэх л юм байлгүй!)



Юүгий нь тэгтлээ хараа вэ, хө?



Ирээдүй гэж, бодоод
байхад сонин юм
шүү, аан?



Намайг битгий ичээгээд бай.
Би амьдрал гээчийн талаар
гүн бодолд автан байна.





Тийм шуу!
Энэ бол амьдрал!
Энэ бол хайр!
Энэ бол бодит байдал!





Би хөөрхөн юм байх даа?
Ээж л тэгэж хэлж байна!

ИНЭЭХ



ЗҮРХЭНД САЙН!



Бурхан минь гэж!



# БУРХАН МИНЬ!



Хэчнээн ч олуулаа байсан Тэр л байхгүй бол би ганцаардаад байдаг юм.



Ээж мөд ирэх болов уу?



Одоо ч би олуулаа байгаад дасчихаж дээ.
Энэ далавчтай шинэ найз маань ч гэсэн!
Ээжийн дэргэдээс тэр сална гэж байхгүй шүү!



Гэхдээ би Ээжийг бусдаас харамлахаа байчихсоон.
Ээж хэлэхдээ ямар ч амьтныг ялгалгүй
хайрлах хэрэгтэй гэсэн.
Тийм болохоор бид нар бүгд ногоон хоолтнууд.





Пөөх! Санаанд багтмааргүй юм!
Өнгөрсөн шөнө үүгээр гахайн торойнууд явж дээ!
Газар нутгаа тэмдэглэсэн үнэрийг маань ч авч
хэлэлцсэнгүй шүү!





Гэрт хүн байна уу?

Би хүрээд ирлээ.
Онгойлгоорой.







Харж байна уу,
Тэр намайг үргэлж "ХАЙРЛАДАГ".





Үүнийг би хаа ч баталж чадна. Харав уу, тэр!

(Бусад маань ч ингэж хэлэх л байх. Гэхдээ л...)













Би бас зурагт үзэх дуртай.



Тэр биеэр том ч гэсэн байдлыг хяналтандаа байлгадаг нь би юм байгаа юм. Нээрээ шуу!



Тэр намайг
ургэлж сонсдог!



Би энэ нөхрийг ч бас "зохицуулдаг".
Бид үнэхээр "чанга залуус".
Гэхдээ тэр намайг босс гэдгийг
мэднэ л дээ!

Тэрнийг Зоро гэдэг.
(Нэрийг нь Ээж өгсөн.)

Мартсанаас,
тэр манай сүргийн 9 дэх нь.

Дахиад бас нэг!
За яахав, Ээж ингээд зогсоох
юм байгаа биз?
Би ийм олон сүргийг "маллаж"
яаж чадахав!



Энэ бол Боосёо. Тэр ...
За байз бодъё... 7 дахь нь билүү, 8 дахь нь билүү,
за нэг тэр хавьцаа л юмдаг.



Энэ модон дотор юу байгаа бол, Бо?



# Lucky

*Lucky-г Флоридагийн нохойн байрнаас авчирсан юм. Тэр анх ирэхдээ аймаар өвчтэй, бараг л "үхлийн ирмэг" дээр байсан тул эмнэлгийн яаралтай тусламж үзүүлж, ихэнх шүд нь муудаад хорхой идчихсэн байснаас шүдний мэс засалд хүртэл оруулах хэрэгтэй болсон. Өгөрч үжирчихсэн амьтан шиг өмхий самхай үнэртээд л. Ганцаар байхаас тэр их айдаг байсан, харин одоо бол зүгээр ээ.*

*Тэр агуу хайрын сэтгэлтэй, эзнээ хамгаалдаг, бас эрх танхи.*

*Хоч нь: Унжуу хэлт, Хөгшин эр, Жимсхэн ("Жимсэнд дуртай"), Пух пух (Гөлөгхөн), Пей пей.*

*Нохойн байрнаас авах үед Lucky өвчинд баригдчихсан байсан учраас бид түүнийг гурван сар асарч сувилах хэрэгтэй болсон.*

*Түүнийг ганцааранг нь хөл хорионд байлгах үед, би түүнтэй тоглохоор өдөр*

*бүр тусгаарлагдсан хашаа руу нь ордог байсан. Тэр теннисний бөмбөгөөр тоглох их дуртай. Тэр цагаас хойш Lucky маань ч сайжирч, намайг шүршүүрт орж байх зуур угаалгын өрөөний хаалганы гадна сэмхэн гэтэн ирж хүлээдэг болсон. Тэгээд намайг хаалгаа нээмэгц амандаа зуусан газрын теннисний бөмбөгөө угаалгын онгоц руу унагаж, надтай тоглох гэнэ!*

*Би түүнийг шинэ жимс ногоогоор хийсэн тусгай хоолоор хооллох болсон. Тэр ч хоолондоо үчиргүй дуртай болж, жимс ногоогүй юм идэхээ больсон доо. Хаа холоос хүртэл жимсний "үнэр авч" чаддаг, за за энэ наргиан шүү!*

*Би түүнд жимсээр далимдуулж өөр юм идүүлэхийг оролддог. Хоолоо идэх дургүй байхад нь хүртэл ганц хэрчим алим харуулахын төдийд мөнөөх "аргалах" алимыг авахын тулд хоолоо иддэг!*

*Тэр өдөр шөнө ялгаагүй жимс идэж чадна, өгөөд л байвал яг л том хүн шиг их хэмжээгээр идээд л байна. Анх уулзах үед харц нь уйтгараар дүүрэн байсныг өнөөдөртэй жишвэл миний хувьд тэр минь томоос том баяр баясал гийсэн, гэмгүй нүдтэй, хөөрхөн "алимхан" болжээ. Олон төрлийн арчилгаа сувилгаа, (чанартай бас өндөр төлбөртэй) шүдний эмчилгээнд орж байж илааршсан учраас бид түүнийг "Арван мянган долларын нохой" гэж нэрлэдэг юм.*

*Эхэндээ түүний бүхий л асуудлыг шийдэх гэж 10000 гаруй ам.доллар зарцуулсан. Ингээд л тэр "Арван мянган долларын нохой" болсон доо. Гэвч миний хувьд тэр юугаар ч сольшгүй үнэт эрдэнэ минь гэдгийг би өөрт нь байнга хэлдэг, тэр ч үүнийгээ сайн мэддэг. Тэр үнэхээр энхрий амьтан - нүүр өгчихвөл өвөр дээр минь унтахаас өөр юуг ч умартаж, бүр жимстэй хамт өгдөг өөрийн дуртай хоолоо хүртэл иддэггүй!*

# "Чи удахгүй сайжирна аа"

Аймаар олон өвчин эмгэгт баригдаж, биеэр минь дүүрэн улаан юм туурчихсан би ирэхдээ...





(Би Hotdog шиг харагдаж байна, гэхдээ иддэг хотдог биш!)

Ээж маань миний өнгөө алдсан үсийг
жимсний улаан өнгөөр будаж өгсөн.

Би улам ч сайхан харагдаж, хөгжилтэй байж,
сайн ч байгаа! Бүр онцгой шүү!
Энэ бүхэн надад таалагдаж байна.



Жаахан шахуалдсан ч
гэсэн дажгүй ээ.
Таалагдаж байна!



Зүгээр дээ.

Булангаа л байж байя.

(Юм юмны л сүүлд байгаа юм шиг л санагдаж байна.)

Би зүгээр дээ, “Үүгээр түүгээр”
жаахан явъя.



Ээж намайг нохойн байрнаас авах үед би ёстой
амь наана, там цаана байсан шүү...



Ээж маань туслахуудынхаа хамт намайг
гурван сар асарсан даа!



"Чи удахгүй сайжирна аа."

Ойлголоо, хатагтай.



Энэ бүхэнд дургүй байгаа юм болов уу!

Би бүрэн тэнхрээгүй байна л даа.

Гэхдээ дажгүй ээ!





Би
дээрдэж байна...

Эдгэрчихлээ!





Энэ бол би,
Lucky!

# Дэлхий дээр мөнх юм гэж ер байна уу?



Ингээд би зүгээр болчихлоо?
Энх тунх, эрүүл саруул!



Дэлхий дээр мөнх юм гэж ер байна уу, Ben?



Найз Benny-ийнхээ хамт.
Тэр илүү жаргалтай харагдана.



Харамсалтай нь үгүй! Гэхдээ Диваажинд бол тийм!



Ёох!...
Юун тоглох!



Энэ миний бас нэг найз.

Би веган нохой болсон.
- Би cool dog, харин hot dog биш -
Би бас бясалгал хийдэг!
Энэ зураг намайг гэрчилнэ.





# Би жаргалтай






Би "жижиг сажиг зүйлд
санаа зовдоггүй".
Том зүйлд ч тэр,
өөр юунд ч би санаа зовдоггүй.



# Аминчхан яриа



Ганцаараа бодсоноос гурвуулаа бодсон нь дээр!



Харин бидний толгой дээр нэгэн гайхамшигтай "Ухаантан" бий.





Эмчид очихгүй байя гэвэл өдөрт нэг алим идээрэй.



Наран гийж байхад бүх юм сайхан шүү дээ!



## Таагаарай



Хэний өвдөг вэ?



Та зөв таалаа!





Өршөөгөөрэй!
Зай алга!



"Намайг" олоорой?
Олж чадах нь уу?



Чи надаас өндөр биш шүү дээ.
Буугаад өгчих л доо, хонгорхон
Ben минь!



Тэгвэл одоо би хаа байна?



Энэ бүхний дараа ч "Тэр үнэхээр намайг дэргэдээ байлгах болов уу?" гэж бодсоор л байна.

Энэ миний аюулгүй байх хоёр, гурав дахь...
Эсвэл суулчийн газар уу?

Та ч бас ирээдүйгээ санаа зовдог биз дээ?
гэх гэсэн юм.
(нэг удаа хаягдаж байсан шүү дээ...)





"Яагаа вэ, Luck?"



Яагаа ч үгүй ээ!
Өнгөрсөнөө жаахан бодоод л!

(Нэг сарын эрчимт эмчилгээний дараах байдал)



Хайртай юм бол

Хөөрхөн болгооч намайгаа!

Тэр! Хараач!









Би одоо хөөрхөн...

...энхрийхэн.





Залуу минь! Би хөөрхөн байгаа биз!



Би бас алдартай од!





Тийм ээ!
Энэ чинь л би
шуу дээ!
Би их... хайр татам.

Ха ха! Хөгтэй юм аа!





Урьд нь ямар байсныг
минь бод доо.





Үүнээс ч илүү цоохор
байсан даа.

Анх ирэхдээ хачин
"саарал" байсан.





Хайртай бөмбөгийг минь өгөөч!

Одоо! Өгчих л дөө!



Санасан бухэн тань сэтгэлилэн
бутсэн гэж бодоод уз л дээ!







Тэр намайг хайрладаг гэдэгт би итгэлтэй байна!



(#1)

Энэ миний дургүй зураг.



Мэдээж энэ зураг нь арай дээр. Зүүн талын #1 зурган дээр толгой маань хагас гарсан болохоор надад таалагддаггүй юм.

Амьдрал маань урьд нь хатуухан байжээ.



Харин одоо бүх юм зөөлхөн!



Тиймээ! Lucky нь байна.
Зургаан сарын дараа.
(Өөрийгөө таньж ядан байна)

Ахиад л би! Хамгийн азтай нь.
(Шилдэг шүдний эмч, малын эмч, амьтны үс засагч дээр очсоны дараа...)



# Зүрх сэтгэлийг уяраагч хайр!

Зүрх сэтгэлийг уяраагч хайр!
Зүүд нойрондоо хүртэл би
аз жаргалыг мэдэрдэг.





Энэ улаан амьтан чинь хэн билээ, санахгүй байх чинь.



# Надад Канад таалагддаг!

Канад аа гэж! Канад надад таалагдаг!
Хэлийг маань цааш нь хийгээд өгөөч, тэгэх үү?



Бурханы авралаар!
Бид тэнд ч нэг их удаагүй л дээ.

Хэл маань орохгүй байх чинь?
Өмнө нь ерөөсөө хөлдөж
байгаагүй л юмсан!



Тэсгим тэр хүйтнийг санахыг ч
би хүсэхгүй байна.
Тэгэхдээ та нарт үзүүлэх гэж хэдэн
зураг дэлгэлээ.



# Бүх юм үнэ цэнэтэй!





Намайг хүлээгээрэй!



Одоо-оо-хон!

За даа... энэ ч нэг
их сайхан санаа биш
байна даа!







Жаахан туслахад
гэмгүй ээ, анд минь!



Хөгшин ч биш л дээ.
Хэт их үдийн хоол...
Энэ... энэ бол татах
хүч!
Энэ бол өгсүүр шат!



Бараг л хүрчихлээ,
Ээж ээ!



Тэгэхээр! Аль ч ууланд авирахад,
бүгд адил үнэ цэнэтэй!



# Бидэнд дандаа сайхан байдаг!



Үүнд дуртайг минь та
мэднэ шүү дээ.
Битгий гүйлгаач дээ!



За, за.



Гүйж байна,
одоо идье л дээ!!!





Ааа......





Ням ням!
Лууван мэрвэл гоолиг болно.



Их идэх ер нь дэмий.
Ургамлан хоол байсан ч ялзаагүй!



Би үүнд ёстой
дургүй
... бүр огтхон ч.





Хаана байна аа
миний олбог??!
бас нөмрөг?

Над шиг ханхүүгийн хувьд ч хэтэрхий "багадах-өвс" байна даа!







Ээж хэлэхдээ:
"Бясалгагч хаа ч
жаргалтай байдаг!"
гэсэн.



Тийм шүү! Гэхдээ энд байх нь арай дээр. Тийм биз?





(Та энэ хоёр зургаас долоон ялгааг олж чадах уу?)
Олчихвол Пудель нохойг аваарай!



Өдөр шөнийн алинд ч найзууд хамтдаа амарч байна.





Энэ чинь харин болж
байна шүү?

Та ингэж
"тэвэрдэггүй" гэж үү!





Нам унтчихаж...
Гоххх...

Би босоогоороо ч
бясалгаж чадна!





Ингэх нь миний сүнсний дэвшилд сайн!
Нохой тэврээд үз, тэгээд л
та мэднэ.



Би өөрийгөө сүүт сэтгэгч гэж боддог болохоор,
яг одоо юу бодохоо мэдэхгүй байна.



Таагүй өдөр хэнд эс тохиолдох вэ дээ?
Гэхдээ зуны сэвшээ салхи мэт,
Өвлийн бүлээн наран лугаа адил
Бидэнд сайхан байдаг.



Миний
зиндааны (!)
бүр надаас өндөр
түвшний бясалгагч

Хаа ч тав
тухтай!
Нээрээ шүү.





Яасан ч байсан
Ээжийн ор бол
миний ор.



Ээжийн байшин
бол миний
байшин.



Өвөр дээр нь байвал
өөр хэн ч байсан хамаагүй!
Би үнэхээр ойшоохгүй!



Намайг хар даа!



Би дийлчихлээ!



Хэн юу гэх нь хамаагүй ээ.
Би үргэлж дээр нь байдаг юм чинь!

Олуулаа бид зургаа авахуулах дуртай!

Ялангуяа үсээ самнуулчихаад эерэг хүмүүстэй цуг байх үедээ.



Энэ шинэ залууг хэн гэдгийг нь таа даа?
(Жаахан дөхүүлэхэд: Тэр исгэрдэг)
Бид хамтдаа ширээн доор
нуугдаж байна.



Үгүй үгүй!
Би түүнтэй (Альберттай) төстэй байгаа биз?
Гэхдээ бид нар адилгүй л дээ.
Оюун ухамсараараа лав биш.
Аан, магадгүй унжсан хэлээрээ,
...эсвэл үсээ засуулсан үедээ толгойгоороо
адилхан байх.





*Түүнийг (Lucky-гийн байсан) нохойн байрнаас авч билээ. Эхэндээ бүрэг ноомой, зожиг амьтан байсан. Харин одоо зүв зүгээр. Гэрийн залуус бүгдээрээ түүнд хайртай. Тэр бодлогоширонгуй нүдээрээ ихийг өгүүлдэг сэн. Хүн, амьтан, өвс ургамал гээд ер нь амьтай бүхнийг хайрлана. Тэр агуу хайрын сэтгэлтэй, үнэнч, эзнээ хамгаалдаг, бас эрх танхи.*

*Хоч нь: Принсиса (Сиси буюу бүрэг охин), Гордита (Испанийн махлаг эмэгтэй), Ваги (Биеэ байнга сэгсэрдэг гэсэн утгатай), Какү (Урьд нь Гекко гүрвэл идэх дуртай байсан).*

*Бусад нохдоос тэр нэг л өөрөөр надтай мэндэлдэг. Унтлагын өрөөнд минь шөнө ганцаараа үлдээд, намайг өрөөндөө орж ирмэгц жүжигчин шиг аяглаж гарна. Толгой, сүүлээ урагшаа хойшоо тонголзуулж, баруун зүүнгүй бүх биеэрээ хөгжилтэй гэгч нь эргэлдэн бүх биеэрээ над руу тэмүүлдэг.*

Боль гээд эрхлүүлэх хүртэл тийн аягласаар л байдаг. Тэгээд өмнө минь суугаад хаа дайралдсан газраа үнсэж, долоож, бусад нохой шиг эргэн хөрвөөдөг. Энэ бүхнийг нь би сайтар дүрслэн хэлж чадахгүй байна. Хүн шиг зориуд, санаатай хийгээд байгаа мэт жүжиглэдэг. Тэр нүдээрээ "ярьж", биеэрээ илэрхийлдэг. Тэр үнэхээр тэгдэг юм!

Нэг удаа бие минь нэлээн тавгүйтээд унтлагын өрөөндөө уйлж суутал Happy маань бүр сандарч яахаа мэдэхээ больсон! Намайг гайгүй болтол нулимс дуслуулсаар тойрон эргэлдэж, орь дуу тавих мэт гийнасаар байсан. Lucky ч өвөр дээр минь гараад гаслаад унасан. Тэгснээ хоёулаа дэргэд хэвтээд бүхэл шөнөжин хажуунаас минь холдоогүй. Бусад нохойнууд ч уяатай юм шиг дэргэд минь байсаар байж билээ!





Хар даа, би ч гэсэн...

"жаргалтайгаар" бясалгаж байна.



Өвөр дээр нь!
өдөр болгон "цугтаа бясалгадаг".




Дуу хуур.





Эсвэл?
Өөр?

Амьдрал гэж юу юм бэ???



Амьдрал энэ хэвээр үргэлжилнэ гэж найдъя.
Тэгэх болов уу?
Энэ миний үүрдийн гэр үү? Мөнхөд хайрлагдах уу?



Яг одоо байгаа шиг,
Амьдрал сайхан үргэлжилж байна.
Нөхөдтэй ч болж
Хайрыг ч мэдэрч байна...



## Хамт байхдаа бид... Хав!



Миний шинэ Ээж намайг
хайрладаг нь эргэлзээгүй!

Өдөр,
хором бүр,
ХООЛ хайрлах бүрт
улам итгэж байна!





Би бол Happy.

Намайг танихгүй байна уу?





Би одоо ч... Happy (гунигтай биш!)
Би зүгээр л үйтгартай болж жүжиглэж
байгаа юм!

...Ердөө л сайн жүжигчин!



# Аяа, Канад!



Би өмнө нь хэзээ ч ийм юман дээр
гишгэж үзээгүй!
Ингэхэд энэ цагаан зүйл чинь юу сан билээ?
Хаанаас ч юм гараад ирчихэж!
Өчигдөрхөн л энд байгаагүй дээ!



Яагаад доороос хүйт оргиод байна!



Ийм маягаар удах юм бол
гарцаагүй хөшөө болох нь дээ!



Өнөөх Happy биш болжээ!



Залуус аа, та нар хаачичихав аа?
Энд нэг их "гоё" байхаа больчихлоо!
Хэн нэг нь хантааз аваад ирэхгүй биз?!

Хамтдаа бол дулаахан.





Чи туугээр, би уугээр явъя.

Нөгөө талд нь цас байна уу,
угүй юу узье!

# Яагаад доороос



хуйт оргиод

байна!

Би ердийнхөөрөө л сууж байна даа!





Хачин юм!

Удах тусам улам даараад байна.

Байрлалаа солиод и нэмэр алга!





Өнөө шөнө энд унтана гэдэг ч сайхан санаа биш байна даа.
Цас малтаж хонхойлоод ч,
цасан хэвнэг нөмрөөд ч хэрэг болох уу ер нь.



Тэр хэзээд хамгийн сайхан байдаг!

Санал нийлэхгүй
байна уу?





"Саад бүү бол".

"Хаалган дээрхийг унш!"







Зай алга уу?



За за,
би доор
суучихья.



Би өвөр дээр суудаг нохой нь.
Надад итгэ л дээ!
Багтана аа!



Харав уу?!



Би өвөр дээр нь л байдаг нохой гэдгээ хэлээгүй юу.



"Мэдээж, тэд жинхэнэ биш".



"Энд бид жинхэнэ амьтдыг хөөж болохгүй".
(Би мэднэ л дээ!)



"ВЕЖИЙ" гэж хэлээрэй!








Хуваалцах уу?
Хуваалцах гэдэг халамжлахын нэр!
гэж Ээж хэлсэн.



Би хамтын ажиллагааг дэмжигч.
Би хаа сайгүй л байдаг.
Ялангуяа хоол хаана, би тэнд.

Энд бид цаг үргэлжид гүйж чадна.





...Үгүй ээ, бид мөнхөд гүйж чадахгүй юм байна!



Би бол мөнөөх Happy!



Ёох... дүг хийх хэрэгтэй байна.

Би томорчихов уу,
энэ сандал жижгэрчихэв үү?








Би "унаагаар явах" дуртай.
Ядаргаа багатай, бас энерги хэмнэнэ.
Бодох санах юмгүй!



Хоцорчихлоо доо!
Тэд үргэлж л маш
хурдан байх юм.

Гялайлаа, ахайтаан!





Би зуудийг тань маная.



Таны хайр бид бүхнээ тэгш хүртээлтэй билээ.



Гэсэн ч сэтгэл минь зовох л юм.
Ээжийгээ үүрд байлгаж чадах болов уу?
Ээжтэй үүрд амьдрах хувь надад бий юу?



Ирээдүй өмнө минь юу зэхнэ вэ?
Бас найзуудын маань өмнө?



Өнө мөнхөд амьдардаг амьтан гэж
байдаг болов уу...?



Зүгээр л "одоо" байгаадаа
сэтгэл хангалуун байя.
Ээж минь намайг байх
учиртай газар луу минь,
Диваажин өөд авч явна
гэсэн!



Хар даа! Би тагнуулч.



Би өдөр бүр шүдээ угаадаг.
Сайхан ч инээмсэглэдэг.



Бас би хөөрхөн.



Би аль ч талаасаа

зурган дээр гоё гардаг юм.





Эрүүл агаар, нарны
туяанд би дуртай.
Зүс царайг минь жавхаалаг
сайхан болгодог юм!

Хаанаас нь ч харсан би
хөөрхөн ч, жаргалтай ч!



За, би
инээлээ
шүү.





Удаан... .... тэсч .... ... чадахгүй нь шиг байна!

Goody минь,
намайг нэг анхаарчихгүй юу?



Суудрээс өөр анхаарлыг чинь татах зүйл
байдаггүй юм уу?
Ядаж ганц ч болтугай сайхан үг хэлээч!

Чамд
ногоохон
веган
яс мэруулье!





Веган яс нохдын
хамгийн сайн
найз.
Чи бүх
эрдэнэсийг ави
болно, оронд нь
"Яс"-аа л өгчих.

Ногоохон ясаа мэрчихээд үдшийн
үлгэр сонсох сайхан сан.



...Тэгээд Цасан Цагаахан Гүнж
мөрөөдлийн Ханхүүтэйгээ уулзсаны
дараа юу болдог билээ?

Тэд насан туршдаа жаргалтай
сайхан амьдарсан байж таарна!
Эсвэл яалаа?

НААШАА



ХУРЭЭД ИР!

Надтай хамт байгалийн сайхныг бишрээч!



Нөгөө талд илуу ногоон өвс байгааг...



... би батлан хэлэх байна.





Амсхийгээд авах минь.

Орилон ертөнц тэр чигтээ минийх.





Өвс ногоо тэндээ сайхан.
Өөрөө би эндээ гоёхон.



Би юу? Үгүй..ээ...
Би бүдүүн биш!
Хажуу дахь хар залуу
маань л харийгүй
туранхай харагдаад
байгаа юм!



За за, чи дийллээ, Ben!



Дийлчихээд баясан хөөрч байгааг чинь мэдэж байна.

Пөөх! Энэ чинь нөгөөх чиний яриад байсан гунжийн шидэт "суул" байна шуу дээ, Ben.







Та нар
хааччихав аа?
Буцаад ир!
Ганцааранг минь
битгий орхиоч.





Би түүнийг үнсэж болох уу?





Сэрээрэй, сэрээрэй!



Ээ... Заавал босох юм уу?
Хоолны цаг болчихсон уу?

Би зүүдлээд байна уу даа?

# HERMIT

*Цаг үргэлж л гүлгих мөртлөө зогсоо зайгүй идэх дуртай энэ Австрали хоточ эр нохойг авч тэжээх сонирхол хэнд ч байгаагүй ээ. Эргэх ч зайгүй жижигхэн дугуй торонд багтаж ядан ахуйдаа тэр зургаан сартай байлаа! Анх би түүнийг авахад бүрэг ноомой, хүнээс аюун цочимхой байсан даа. Харин одоо бол огт өөр. Хайрын сэтгэлтэй, үнэнч, эзнээ хамгаалдаг, эрх танхи.*

*Хоч нь: Гал тогооны комбайн, Хэ Хэ (үргэлж аахилдаг), Чип Ахой (шоколадны жижиг хэсгүүдтэй жигнэмгийн өнгө), Улаан хөх Бадмаараг (нүд нь улаан толботой хэрнээ өдрийн цагаар хөх харагддаг), Магтаалд дурлагч.*

*Тэр миний болон танил хүмүүсийнхээ дэргэд үргэлж хөөрч баясч явдаг. Та түүнийг эрхлүүлэх юм бол бүхий л хорвоод танаас өөр хэн ч байхгүй мэт хайр гэрэлтсэн, биширэнгүй харцаар нүд рүү тань ширтэх болно. Танд ер бусын онцгой, цэлмэж хайрын мэдрэмж төрөх болно.*

*Тэр бусад ноходдоо сайн боловч хүн болгонд бас итгээд байхгүй ээ. Надтай цуг байхдаа хэнийг ч ялгалгүй хүлээн авах боловч цаадуул нь дөхөж ойртох гэвэл дөлж зугтана. Миний араар нуугдаж, хүн амьтны бараа харааггүй юм шиг бишүүрхэнэ. Гэсэн хэдий ч таныг найзаа, эсвэл гэр бүлийнхээ гишүүнээ гэдгийг мэдвэл бусдаас илүү дотносож, хүндэтгэнэ.*

*Бусад нохдтойгоо найрсан, ноцолдох бүртээ тэр ямагт дийлнэ. Агаарт ч, газарт ч теннисний бөмбөгийг бүхнээс түрүүлэн амаараа "барьж" чадна. Goody амжаад бөмбөг ч юм уу, өөр тоглоомыг зуучихвал амнаас нь найрсгаар булаагаад л авчихдаг ухаалаг нэгэн. Ялагч болохоор зөрүүдлэн зүтгэдэг!*

*Газарт хэчнээн тухгүй байсан ч, зөөлөн оронд орох гэхээсээ хөл тушаа минь сууж байх дуртай! Нохдын маань дийлэнх нь яг л түүнтэй адил эрх танхи.*

*Хүмүүс Бурханд өөрсдийгөө ийн зориулах аваас Диваажинд гарцаагүй залрах ерөөлтэй билээ!*


Энэ хаалгаар
зөвшөөрөлгүй
орох гэж хичээсний
хэрэггүй!


Гэсэн хэдий ч би
найрсаг харагддаг.

Тэгэхээр, тийм биш байна гэж үү?





Яг үнэндээ
би усан цэрэг болно гэж
хэзээ ч бодож байсангүй.



Сэлэх ч...





жаахан хэцүү шүү!

Goody, чи нэг юм сонсов уу?



Аан-хаа! Тэд биднийг сэлуурдээд
зараад ир гэээд байгаа юм байх даа!





"Завиар" аялахад сайхан байлаа шуу.




бас царайлаг нь!



Ямар алдартай загварын нохойтой би адилхан харагдаж байна даа?




Миний бодлоор би хамгаалалтын
мундаг нохой л юм уу,


арслан, эсвэл


сүнсний
дүрд
тоглож
чадна!


Ай даа!
Надаас хөөрхөн амьтан
хаа байна?

Магадгүй...магадгүй шүү...









...эсвэл магадгүй... чон!





Ухлийн дараа
амьдрал байдаг
болов уу?
Юуны учир би энд
байна вэ?



Ойр дотныхныг маань олон олон амьдралын
туршид надтай цуг байлгах боломжтой
болов уу? (Тэдэндээ би үнэхээр хайртай!)
Тэднийгээ би алдмааргүй байна.



Өнгөрсөн болон ирээдүйн
тухай асуултуудад маань
хэн хариу өгөхсөн бол?





Аниргүй бясалгал хийхээр
хичээн суувч зүрх сэтгэл
минь зүг бүрт хэрэн хэсүүчилнэ!

Ганцаараа байхаас сайхан юм хаа байх вэ!



Энд ингээд үлдсэн ч би чадна... өнө мөнхөд.





Их Багш хэлэхдээ: "Бясалгал бүхий л асуудлыг шийдэх шидтэй" гэсэн.
(Гэхдээ надад юуных нь асуудал байх вэ!
Ээж бүгдийг нь шийдчихсэн юм чинь.)







Ойд юутай хурдан харанхуй болно вэ.





# ТУСЛААРАЙ!

Багш минь! Ээж ээ!
Намайг гэрт минь хүргээч!





ТАЙВАН БАЙ!

Харцгаая...

Элс ч юм шиг харагдаж байна, тэгсэн хэрнээ элс биш ч юм шиг! Хөлд шигдэж ороод, хүйт оргиулаад байх чинь!



Газар дэлхийг хучсан...энэ юм чинь...юу билээ?



Гэхдээ... сайхан байна аа!
Шив шинэхэн, сэв сэрүүхэн...














Өө! хөө!... үнэндээ...
би хангалттай...
дасгал хийчихлээ!



Яаж цасан дээр бясалгал

хийдэг юм бол?







Энд хүйтэн л байна.
Гэсэн ч би юу юугүй зүүрмэглэх
гээд байна даа.

зүүрмэглэх
зүүрмэглэх
зүүрмэглэх

Ай даа! “Тэрээс минь сайхан газар гэж алга”





Энэ зүгээр ч нэг гэр биш,
энэ бол миний Диваажин!









Эдгээр зургаас хоёр хоточ нохойны 4 ялгааг олж чадах уу?





Тийм бол нохойн асрамжийн газраас нэг адилхан нохой авч өөрийгөө урамшуулаарай.

Тэднийг завгүй байх зуур юухан ийхэн амтлаад үзвэл яасан юм.



# Таал Даа

## Хэн юу идэж байна?



Үүнийг бид хоолны өрөөн дэх ногооны савнаас авдаг, үргэлж л! Хэн ч хэзээ ч юм хэлдэггүй!



(ХАРИУЛТ НЬ: Арын хуудсанд бий.)



Би түүхий төмс зажилж байна!





Аан-хаа! Намайг "үйлдэл дээр минь" барьчихлаа! Гэхдээ төмс маань дуусчихсан. Ямар ч үл мөр байхгүй (Lucky бид хоёр идчихсэн)

Гэвч лууван үлдчихэж. За яахав!...Гурав дахь нь юм чинь.






Хоорондоо тэс өндөө ч гэсэн хамаагүй ээ.







# Хөөе! Зургийн аппарат аа!

Та нар цэнхэр нүдтэй Австрали хоточ нохой харсан уу, ер нь?

Хэ!Хэ!Хэ!



Goody минь ганцаараа гүй дээ. Би жаахан амраадахъя.



Шатаар авирах ч амаргүй байна! Хийсэн хүн нь ууганаар нохой авирна гэж бодсонгүй дээ!



Гэхдээ "Ээж" дээр нь байгаа бол би авирах л болно.
—Ингэхэд, би үнэхээр чадах болов уу?


Бурхандаа залбирья!


Хар даа! Би гарчихлаа!


Тэд ч бас!






Таны зөв шуу. Надад орон зай хэрэгтэй.



Happy юу үүгаад байна аа?



Юу байгааг нь харцгаая!









# Үлгэрийн цаг...

унэхээр сайхан шуу

Z

Z

Z

z

Ингэхэд ээж хаана унтах болж байна аа???





“Ээж ээ, та ‘миний’ орон дээр үнтаж болно шүү!”
(Үг нь Ээжийн ор л доо.)



"Би ч явсан нь дээр юм шиг байна!..





...шалан дээр тухлан суугаарай. Баярлалаа!"



# GOODY

*Тэр жижигхэн дөрвөлжин торонд хоригдчихоод, хөдөлж ч чадахгүй, яс арьс болтлоо турж, өтгөнөө идэхдээ тулчихаад байсан бөгөөд түүнд хоол унд ч өгөлгүй гаргаад хаяхад бэлэн байв! Анх ирэхдээ аймаар их өвчтэй байсан тул хоёр сар тусгаарлан эмчлэх шаардлага гарсан юм. Одоо тэр сайн байгаа. Сүүдэртээ тун ч дуртай. Тэр хайрын сэтгэлтэй, үнэнч, эзнээ хамгаалдаг, бас их эрх танхи. "Тэврэхэд" дуртай, эрхэлмээр үедээ тэр таныг "тэвдүүлэхэд" хүргэнэ. Эрхлүүлэхгүй бол дэргэд тань суугаад "мөнхөд" хүлээж мэднэ.*

*Хоч нь: Сүүдрийн ангууч, Самурай, Ид шидтэн, Шүлс ихт (Хоол гуйхгүй хэрнээ зүгээр л хаа холоос шүлсээ гоожуулаад л байна).*

*Тэр гэр бүлийн гишүүдтэйгээ тун ч боловсон харьцдаг. "Том ах" Веппу өөдөө хэзээ ч "хариу хуцдаггүй". Hermit-эд бол хүссэн болгоныг нь, бүр амандаа байгаагаа ч найр тавин өгдөг ба*

*хоол болон тоглоомынхоо төлөө өрсөлдөнө гэж үгүй. Хүмүүст ч ялгалгүй тэр найрсаг хандаж, гэр бүлийнхээ хэнийг ч ирэхэд нь ямар нэгэн хайрын илэрхийлэл болгож таны гэрийн шаахай, дэр, гар утас, зурагтын удирдлага зэргийг дүүрэн шүлстэй амандаа зуусаар угтдаг. Тун мэдрэмжтэй учраас хүмүүсийн энергийг мэдэрч хариу үзүүлдэг хэдий ч тэр бүр нялуураад байхгүй. Ер нь бүх Ротвелирүүд адилхан байдаг байх л даа. Гэхдээ л тэр хайрлаж, хайрлуулж чаддаг ер бусын нохой. Танд хэзээ ч төвөг удахгүй. Чимээгүйхэн өөрийнхөө, эсвэл модны сүүдэртэй тоглоод л байж байдаг. Ганцаараа өөрийнхөө тоглоомын зүг архираад л, заримдаа хайрлуулмаар санагдаад, хүний хайрыг өөртөө татмаар байвал цөхрөлтгүй оролдоно доо!*

*Хүмүүс түүнийг өөрийнхөө ойр байлгахыг үнэхээр хүсэхгүй бол ичээд л холдоод явчихна.*

*Эрэмгий зоримог эр нохой хэдий ч их л найрсаг, хөөрхөн амьтан байгаа юм!*



Бидэнд арьс өнгөний ялгаа огт хамаагүй!
Бид хэзээд хамгийн шилдэг
анд нөхөд.





Та нар миний юу хийх дуртайг тааж чадах уу?
(Дөхүүлээд өгье: Гар чийдэнтэй холбоотой ямар нэгэн зүйл хийх)

Нохойгоо тэврэн энхрийлж, тэднээр үнсүүлэн өөрийгөө шагна.

Хэрэв танд нохой байхгүй бол, авч тэжээх боломжтой бол яг одоо яваад, миний баатар болоорой!

Баяр хүргэе!



Би бол сүүдрийн ангууч.

Яг зөв! Сүүдрийн ангууч!
Би бол сүүдрийн ангууч!



Гэрлийг нь эргүүлээд гаргачихъя





Байраа эзлээд!
Бэлдээд!
Бариад!



?

Сүүдэр хаачихав аа?

Бид бол...



Сайн найзууд!



Хайр бол нэгэн зүгт харахын нэр!





"Ийм сайхан байгальд
харахыг хүссэн зүйл чинь
ердөө л сүүдэр байх гэж!"

"Намайг
сүүдэртэй ...
ганцааранг
минь
үлдээ!"



Модон доор зөндөө олон сүүдэр байна



Гэвч энэ надад муу нөлөөтэй!
Яагаад зун л ийм байх ёстой гэж?
Байнга л халуу шатам байх юм!





Сүүдэртэй хөөцөлдөх
ч ядрааж байна шүү.



Дэргэд чинь
үлдэхэд сайхан
байна!

Хайр аа!



Дуг хийх
зуур чинь би
эргэн тойрноо
харуулдаж
байх уу?



Тэг дээ,
эрхэм анд
минь!





"Хуваалцана гэдэг сайн үйл юм"
гэж Их Багш хэлсэн.

Инээмсэглэл маань ийм хосгүй сайхан байдгийн учрыг та мэдэх үү?



Хариулт:
Учир нь гэвэл би өдөр бүр шүдээ угаадаг юм. Үнэн шүү!





Суудэр өгөх хэн нэгэн байна уу?





Гэрт туссан
сүүдэрт би дуртай.



Гадуур чөлөөтэй
зугаалах сайхан.
Үнэхээр гоё!

Гэви
би хаанаас ирсэн билээ,
хаашаа би явах вэ???



# Одооноос Түүний хаа байгаа газарт би явна.





"Инээмсэглэнэ" гэж яахыг хэлдэг юм бол?

Инээнэ гэсэн үг үү?





Эсвэл инээнэ гэсэн үг үү?



За за, ойлголоо. Инээж дүүрэн инээмсэглэхийг хэлдэг байх нь.



Би аймаар харагдаж байгаа биз? (Энэ зурагчинг үү!)

За за, би араа шүдээ нуулаа.





"Бяслаг" гэдэг үгийг март даа.
Энэ удаад би шүдээ гаргасангүй.
Өмнөх зургийг маань аймаар болгочихсон байсан шүү.
Тэр зурганд би ёстой дургүй!



Зургаа дарчихсан уу?
Жаахан амраад, "тайтгаръя".





Энэ мод амьд.
Тэр мод өмхөрсөн.
Юутай түрхэн зуурын
үзэгдлийн дунд би байна вэ!
Мөнхөд орших зүйлийг ямар
ихээр хүснэ вэ!









Би зөвхөн
өөрийнхөө сүүдрийг
л харж байна!





Заримдаа тушиж тулах зүйлгүй орь ганцаараа мэт санагддаг.





Hermit найз минь, чи толгойгоо
ийш тийш хөдөлгөхгүй юу, аан?
Би сүүдэртэй чинь жаахан тоглоотохьё,
тэгэх үү, Her?

Анд болоцох





хэн нэгэнтэй хамт байх гэдэг хэчнээн сайхан гээч. Нөхөрлөсөн хэвээр.



Би нуугдаж болох
сэрүүхэн газар
хайж байна.



Энд сайхан байна!
Сүүдэртэйгээ
хөөцөлдөөд л.








Намайг "олчихлоо".
Би энд байна!
Гэртээ эргээд ирлээ.



Энэ зугээр и нэг "ногоон яс" биш

Гол нь **хайр** шингэсэн байгаа!

Хатагтай энэ бол унэхээр унэн шуу!






Ногоон яс бол туунийн
хувьд эрх чөлөө
Харин надад бол...
ням ням...





Ахиад нэгийг
өгчих л дөө.
Би томоотой
байна аа!
Тэгэх уу, Ээж ээ!



Би хөөрхөн биш
байна гэж үү?



Хөөрхөн биш гэж үү?





Гэртээ байх сайхан гэдгийг би хаа ч хэлнэ!...

...бас найзуудтайгаа байх гоё.





Үнэхээр тийм байгаа биз?



# Би ганцаардахаа...



...больсон!







...ор дэр бол сүнсний дэвшилд минь сайн! Тийм ч болохоор...



...яагаад заавал Гималай явж, тэндээ үлдэх хэрэгтэй гэж!...






Үүний төлөө чармайх хэрэгтэй дээ шүү.



Би бусдаасаа арай хүнд юм уу даа?

Дэндүү өндөр юм даа.
Шаттай сан бол ч.



Энэ янзын
сүүдрийг яаж барих вэ?









Ээжийнхээ



эзгүйд ядаж л үнэрийг нь үнэрлээ.

Энэ бухэн хий хоосон зүйл и үнэхээр
хүйтэн байна шүү!
Одоо бас юу билээ! Цас орчихож...
Аль хэдийнээ юу?
Өө!



Ямар гээчийн цаг агаар вэ!
Нар, цас хоёр нэгэн зэрэг байх юм!
Миний сүүдэр намайг будилуулаад байна.





Энд зогсоход нэг л жигтэй байна.





Доошоо бүр шигдээд байх юм! 'Сордог цас' биш байгаа даа?

Түргэн сэтгэх хэрэгтэй!



Ийм нөхцөлд Их Багш маань юу хийх байсан бол?



Явсан нь дээр юм байна.



Гэвч хаашаа явах вэ?
Хаа сайгүй цас байхад!





Йогчид Гималайн ууланд яаж бясалгал хийдэг байна аа!!!
Зарим нь бүр юу ч өмсөхгүй шүү. Тэднийг "Нага" гэдэг гэж Их Багш хэлсэн.
Харин би энд удаан байвал
"Нада" юу ч үлдэхгүй болчихож мэдэх нь!

Дулаан хантааз йогчдод нэг
их тээр болохгүй гэж бодож байна...
яланГуяа надад!...



# Boyo

*Boyo (Бо Бо) бол Унгараас ирсэн нохой. Эхэндээ тэр хүйтэн хөндий, зожиг, аймхай нохой байж билээ. Буланд шигдэж, аянга цахилгаанаас айдаг байсан. Анх намайг харсан дороо үнсэхээр зүтгэж билээ. Одоо тэр зүгээр ээ. Миний өрөөнд унтах дуртай (ер нь ноход маань бүгд л тийм дээ). Бие хаа нь ч нэлээд чанга чийрэг болсон. Эхэндээ түүний толгой нь биенээсээ "дүүжлэгдээд" явж байгаа юм шиг хачин жигтэй харагддаг байлаа (бие нь дэндүү туранхай, толгойгоо даахгүй байгаа юм шиг). Цэхэр цайвар үс нь арьсыг нь ч далдалж чадахгүй шахам (-30 хэмийн хүйтэнд) байсан.*

*Одоо тэр зүгээр болсон. Тэр хайрын сэтгэлтэй, үнэнч, эзнээ хамгаалдаг, бас эрх танхи.*

*Boyo тун их хайрын сэтгэлтэй бөгөөд талархлаа үргэлж илэрхийлэх хэдий ч аянганаас айдаг хэвээрээ. Аянга цахиллаа л бол өрөөнд минь хар хурдаараа гүйн орж ирээд нуугдаж, тэгээд тэр өдөржингөө юу ч, бүр дуртай хоолыг нь өгсөн ч иддэггүй! Хоргодох газаргүй байх цэдээ тэр юу мэдэрч байсныг би төсөөлж ч чадахгүй нь.*

*Тэр миний дэргэд аль болох ойрхон хэвтэх дуртай. Ор дэр, буйдан, дулаахан хөнжлөө хүртэл тоож харахгүй. Тэр бол үнэхээр боловсон залуу. Найз Lady-дээ үргэлж найр тавин өмнөө оруулж, хамгаас дуртай ногоон ясаа хүртэл хуваалцдаг.*

*Тэр хүмүүст үргэлж намуун зөөлөн, эелдэг, бас хайрлаж ханддаг. Гэвч аль нэгэн шинэ нохой гэрт үймээн шуугиан таривал Boyo маань асуудлыг зохицуулахын тулд харин ч нэг булчингаа чангалж мэднэ шүү.*

# БОБО



"Өмнө нь"

Би бол Boyo (Ээж маань намайг өхөөрдөн "Бо" буюу "БоБо" гэж дуудаг). Би урьд нь иймэрхүү л амьтан байлаа (Би өмнө нь ийм харагдаж байснаа хэлүүлэх үнэхээр дургүй л дээ). Хүйтэн хөндий саравч, гав гинж, өдөр болгон өгдөг хөлдүүс болсон хоолыг одоо ч санаж байна. Тачирхан ус арьсыг маань ч халхалж дөнгөдөггүй байсан. Шөвийсөн том толгой маань биенээсээ ангид юм шиг харагддаг байсан биз. Бохир оромж намайг цас бороо, салхи шуурганаас хамгаалж ул чадна. Хасах 30 хэмийн хүйтнийг бол бүр ч ярилтгүй...




ОДОО БИ ИЙМ ХАРАГДДАГ.



# Ямар гоё
## ...гээч...



"орондоо өглөөний цайгаа уугаад л"!





Гадаа аянгатай байхад
тийм ч аятайхан
санагддаггүй!

Өрөөний үйлчилгээ өнөөдөр
удаан байна шүү,
залуу минь!

Би болчихлоо. Ус!





Энэ бол миний
хун анд

бас миний хайр!



Энэ бол миний цэцэрлэг
(бид бүгдийнх, гэхдээ л минийх).



Миний найз, хар и гэсэн эелдэг!

# Ийм цаг агаарт дурлахгүй хэн байх билээ?



Гэвч...
би гадаа
удаан байх
дургүй байсан.



Зөвхөн тэнгэрээр дээвэр хийж гадаа амьдарч байхдаа Унгарын хүйтэн өвлүүдийг тэсч үлдсэн гэдэгтээ итгэж ч чадахгүй нь!



Цас, мөс ямар байдгийг ч мартчихаж...



Хаалганы гадна байх онцгүй.
Удаан байлгахгүй байлгүй дээ.



Би гэртээ хайртай. Би буйдандаа дуртай.





# Яагаад гэдгийг та хараач дээ!





Эндхийн бүх юманд би дуртай.
Амттай хоолондоо ч дуртай.

Хивсэндээ би дуртай.







Найзуудаа ч
бас хайртай.

Хайр халамж, гэрийнхээ
халуун илчинд би дуртай.










Энэ зурганд хуурмах хэрэггүй.
Би огт ганцаардаагүй.





Одоо ч би гадаа удаан байх дургүй.

Ялангуяа бороо орж, цахилгаан цахилж, тэнгэр дуугарч байхад! Хэцүүхэн цаг агаар намайг айлгаж, бас цочирдуулдаг. Би их мэдрэмтгий л дээ! Үүнийг хэн ч мэддэггүй юм. (Гэхдээ Ээж Воуо намайгаа хайрлан халамжилдаг!)

Орон гэр минь!
Наддаа л диваажин.





# Би үргэлж сайн нохойн эзэн байдаг

# Энэ бол миний гэр



Одооноос эхлээд бусдаар хайрлуулна гэдэг энэ дэлхийн хамгийн гайхамшигтай зүйл гэдгийг чи мэдэх болно.




ПомПом!
Энэ ногоохон ясаа дуусгахгүй байх боломж ер нь байна уу?




...зүгээр л асуусан юм! Тэгээд л...


Үгүй гэж хэлэхийг тань мэдсэн юм.

# Бясалгах аа?



## Бясалгах аа?

Бид түүнийг чинь
өөрсдийнхөө аргаар хийнэ ээ!


Буйдан дээр хэвтэх нь арай дээр!


За, тэр! Би үүнийг л хэлээд байгаа юм шүү дээ?


Янзтай! Дулаахан, бас гоё зурагтай.


Энэ их үнэтэй гэдэгт мөрийцсөн ч бэлэн байна.

Гэхдээ Ээж шалан дээр бясалгах нь илүү гэсэн



яаж мэдэх вэ, унахдаа хурвэл айхтар юм болохгүй... (тийм биз!)



Өмнө нь надад ийм хөнжил хэзээ ч байдаггүй байсан!



Энэ цас шиг өнгөтэй. Гэхдээ хэчнээн дулаахан гээч! Үнэхээр таалагдаж байна. Баярлалаа, Ээж ээ!



Буйдан дээр сууж байгаад
Будда болсон хэн нэгэн
байдаг болов уу гэдгийг
би мэдмээр байх юм?





Заримдаа нуугдах зоё байдаг юм.
Тэнгэрийн аянганаас нуугдаж болно.
Ээ хөөрхий, нуугдах ч газаргүй ямар аймшигтай байв даа!






# ГАЗРЫН

(Заримдаа л)

Happy миний нуугддаг
газар орохыг би
зөвшөөрдөг юм
(гэхдээ зээлээр).



Өвөлдөө ажиллуулдаг жинхэнэ
задгай зуух бидэнд бий.
Бид тойроод цугтаа суудаг юм.
Ай! Газар дээрх Диваажин!

# ДИВААЖИН

# LADY

*Lady бол хүчтэй, хайр хүрэм гайхалтай найз юм. Түүнийг Унгараас авчрахад бүх үс ноос нь даахирч ширэлдчихсэн, бохир заваан байсан. Одоо бол зүгээр ээ. Тэр агуу хайрын сэтгэлтэй, үнэнч, эзнээ хамгаалдаг, бас эрх танхи.*

*Анх уулзмагцаа би Lady-г суу гэтэл тэр хүсэлтийг минь тоолгүй яваад өгч билээ.*

*Харин явуулын чингэлэгт хамтдаа унтсанаасаа хойш илүү нийцтэй болж ирсэн. Одоо бол намайг харах бүртээ юу ч хэлээгүй байхад л чимээгүйхэн суугаад эрхлүүлэхийг, эсвэл түүнд хоол өгч, "Сайн Охин" гэж магтахыг минь хүлээдэг.*

*Бусад ноход бужигнаж, эргэн тойронд нь дуу шуу болж байсан ч тэр ер тоохгүй*

чимээгүйхэн суусан хэвээр байж, "Сайн Охин"-ы эрхэмсэг төрхөө хадгална.

Харах тоолондоо би түүнийг тэврэхээс өөр аргагүй болдог. Ялангуяа ийм байх үед нь үнэхээр биширмээр байдаг. Хэдийгээр хатуужилтай ч гэлээ эрхлүүлэхэд минь муурын зулзага шиг цээжээ хэржигнүүлэн, дөрвөн хөлөө дээш харуулан эрхлэх юм уу эсвэл өөр байдлаар авирлаж, эрхлүүлэх хүслийг минь үнэхээр хүндэтгэж үздэг. Би энэ охинд хайртай. Түүнийг би миний Гүнж, Жигнэмэг, Чоко (шоколадны өнгөтэй учраас) гэж дууддаг. Тийм л хайр татам амьтан даа!

Тэр өдрөөс өдөрт улам л намуун зөөлөн болсоор буй. Түүнийг хайрлахгүй байхын аргагүй байдаг!



Би Унгараас ирсэн Lady байна.
Танилцахад таатай байна, найз минь!



Lady: Ахлагч Kyyk-ku.
Хөлөө өргөөд, хөвгүүд шиг аягалана.
Хэнээс ч, юунаас ч айхгүй!

Их уян зөөлөн харагддаг, Гэвч тэр үнэхээр хүчирхэг. Түүгээр тохуурхах гэсний хэрэггүй. Хол байсан нь... дээр.

Юү!!... Энэ бол надаас
хүсэн хүлээж болох хамгийн
сайхан инээмсэглэл.
Би урьд нь хэзээ ч камерийн
өмнө инээмсэглэж байгаагүй!
Ер нь л би инээдэггүй байсан.







"Ээж"-тэйгээ учрах хүртэл ийм л байсан.
Өмнө нь ямар байсныг минь санаж байгаа биз дээ?
Дурсамж юүгий тань сэргээх тул
дараачийн хүүдсаа нээгээрэй!





Би цасанд ердөө ч дургүй, ялангуяа Унгарт ордог цасанд.
Өвөл тэнд тун хүйтэн (-30 хэм хүрдэг).



Ширэлдэж эвгүй үнэртсэн урт үстэй
байсныг эс тооцвол урьд нь би нэг
иймэрхүү л харагддаг байлаа! Үсний
тухай огтхон ч мэддэггүй байв.
Зүүн нүдний минь сүрхий сорвийг
Ээж харах толондоо хүрц зүйлээр
"хатгуулчихсан" мэт болдог!


Би гэртээ байх дуртай.


Би гадаа байх дуртай.


Энэ хүмүүнийг зөөлөн илэхэд би дуртай.


Би хайр гэдэг зүйлд их хайртай!



Би иллэг
хийлгэх
дуртай.



Үгүй ээ, би
үхээгүй,
зүгээр л
тухлан хэвтэж
байна.





Дотор

эсвэл гадна

Амьдрал
ямартай ч
хав хав! ♥





Энд
яг л



# Диваажин



Яг л
Диваажингийн
амт шиг
(нохойн хэлээр)

Ээж ээ,
Ахиад
авч болох
уу?

Тэгэлгүй яахав,
хайр бол
хамгаас
сайхан.



Тийм ээ, гэхдээ...
Ногоон-
яс үнэхээр
янзтай!







Амьдрал бол
үнэхээр, хав хав...
үүнийг та л бий
болгоно.



...Би тэгж
бодож байна!





Би эр нохой шиг хөлөө өндөр
өргөж бас чадна шүү!

Тэдний хийдгийг би ч бас чадна.



Би хөвгүүдийн хэнээс нь ч дутахгүй!



Lady би вээр таниас эхлүүлээд бүхий л эрчүүдийн дунд хяналт тогтоонo гэдгээ тунхаглаж байна!



Амьдрал ер нь л “ЯНЗТАЙ”.



Янзтай... цэмцгэр гэр орон,
цэлгэр шал!

# Нохойтой ярьсан яриа









Би хоолондоо дуртай.
Би гэртээ хайртай.



Би хатагтайдаа хайртай,
тэр ч гэсэн надад!



Би цэцэрлэгтээ хайртай.
Би байгальдаа хайртай.





Энэ бүхэнд би хайртай.
Хайргүй хэн байх билээ?
Өөр олон зүйлд хайртай...



Энэ бүхний дараа
аз жаргалтай
амьдарч байна.

# Pomas

*Pomas-ыг Унгараас авчирсан. Тэр бүрэг ноомой, зожиг, том нохдод дээрэлхүүлсэн амьтан байлаа. Одоо бол өөр өө! Хүчтэй, өөртөө итгэлтэй болсон. Өөрийг нь дээрэлхэх гэсэн ямар ч нохойны өөдөөс сөрөн зогсч чадна.*

*Тэр агуу хайрын сэтгэлтэй, үнэнч, эзнээ хамгаалдаг, бас эрх танхи. Тэврүүлэхийг хүссэн цедээ чимээгүйхэн дөхөж ирээд толгойгоо өвөр дээр тавина!*

*Хоч нь: ПомПом, Женти (тансаг), Хөөрхөн Хүү.*

*Pomas бол бүх нохдын маань дотроос хамгийн даруухан бөгөөд эгдүүтэй нь! Төвөг удна гэж үгүй. Хэзээд сэтгэл дүүрэн явдаг тэр амьтан харсан бүхнээ хайрлах хүсэлтэй.*

*Боломж л олдвол над руу чимээгүйхэн дөхөж ирээд өвөр дээр минь толгойгоо зөөлхөн тавьж, хайраар "цэнэглэгдэхийг" хүсдэг. Ноход бас ингээд ирвэл бусдадаа зайгаа тавиад л өгчихнө.*

*Өмнө нь Boyo-той ширүүн дориун цэлцсэн хэдий ч тэр үргэлж эхлэн найр тавьж, хайраа илтгэн нуруугаараа хөрвөөж, цаадахыгаа үнсэн долоож аргаддаг. Тэгээд мэдээж хүмүүсийг тэр хайрлан хүндэтгэдэг. Ямар ч хүн түүний хувьд анд нөхөр нь. Тэр хүнийг ямар ч эргэлзээгүйгээр хайрлаж, хүндлэх учиртай гэж боддог! Түүний уриа бол "хамтдаа орших".*





# Хүйт даасан өдрүүдэд би яаж амьд үлдсэн юм бол доо!

Намайг Potas гэдэг (Ээжийн охоордон нэрлэснээр "Поми" буюу "ПомПом").

Үнэндээ бол би үүнээс илүү царайлаг л даа. Энэ зурган дээр би бүрэг амьтан шиг харагдаж байна! Гэхдээ... Ээж намайг авахаас өмнө үүнээс ч дор байсан нь үнэн. Бохир үс маань даахираад ширэлдчихсэн, өвлийн өдрүүдийн туршид нойт даасан, хүйтэн хөлтэй байдаг байсан.

Тиймээс ихэнхдээ л би Boyo-гийн үүрний дээвэр дээр гарч хэсэгхэн хугацаанд ч гэсэн хуурай байх гэж хичээдэг байж билээ. Яланзуяа өвлийн хасах 30 хэмийн хүйтэнд, хаалгагүй үүрэн дотор гадаах хүйтнээс огтхон ч ялгаагүй байсан.





Над дээр зочлоод ирэхэд нь би "Ээждээ" хэлсэн юм. Тэгээд тэр надад хавьгүй дээр оромж барьж өгсөн. Ер нь тэд бүгд л байрыг минь барихад туслахыг хүссэн. Гэсэн ч би өдөржингөө л даарч, шөнө нь бүүр ч хүйтэн байсан.

Хүйт даасан өдрүүдэд би яаж тэсч үлдсэн юм бол оо гэж гайхдаг. Шөнөдөө тачигнасан хүйтэн болох үед би ухаан алдчихдаг байлаа. Үргэлжийн гинжтэй байх нь үүнээс ч дор байсан. Дараагийн эзэд маань сайхан хүмүүс байлаа. Намайг сул тавьсан учраас би эргэн тойронд явж чадах болсон.




Унгарт өвлийн хүйтэн унэхээр бэрх шуу. Гэсэн ч би тэсвэрлэдэг байсан!

Эхлээд тэд Ээжид "ноход хүйтэнд дасчихдаг" гэж хэлсэн. Үнэндээ бол бидэнд гадаа байхаас өөр сонголт байгаагүй л дээ.

Асуусан бол бид өөр зүйлийг хэлэх байсан. Хэд хоногийн дараа Ээж маань энэ бүхнийг тэвчиж чадалгүй намайг өөр хоёр нохойны хамт өөрийнхөө тур амьдарч байсан жижиг чинээлэгтээ аваачсан юм.

Халуун дулаан уур амьсгал, шинэ сайхан хэвтэр, булээн цэвэр ус гээд л бидний хувьд энэ бугд орд харш байсан. Бид туунийи жижигхэн орны дэргэд унтдаг байв. Туслахууддаа Тэр биднийг цагаан цууны уусмалаар цэвэрлэж, чийгтэй алчуураар арчаад байрандаа аваач гэж хэлсэн. Тэр биднийг халуун дотноор хулээн авч, хайрлах болсон доо! Туунтэй уурд хамт байх нь бидний хусэл байлаа. Амьдралын маань туршид анх удаа халуун хоол өгсөн хун бол Тэр юм!





Ажлаа дуусгаад Тэр шөнө бүр бидний-г өрөөндөө оруулж, өөрийнхөө хоолыг хуваалцаж, эсвэл зузаан хэрчиж, хайрсан талхан дээр хайлуулсан цөцгийн тос түрхээд өгдөг байв! Бидний зүрх ч бас уяран хайлсан. Өвлийн тэсгим хүйтэн шөнө цөцгийн тостой хайрсан талх шиг сайхан амттай зүйл өөр хаа ч байхгүй!

Тэгээд Тэр бид бүгдийг хаашаа ч явсан хамт л авч явж байсан. Үйлчилгээ маань ч улам сайжирсан. Амьдрал маань алга урвуулсан мэт сайхан болсон...



Би цаг үргэлжид аз жаргалтай байх болсон. Биен дээр маань урьд нь их олон шархтай байсан санагдаж байна.

Үсанд оруулж үсийг маань засах үед шарх сорвинууд ил гарч ирсэн. Ээж маань үүнийг анх харчихаад нулимс унагаж, намайг чанга тэврэн авч билээ.

Гэвч би түүнд санаа зовох хэрэггүй ээ гэж хэлсэн.
Сэтгэлийн маань шарх аль хэдийнээ эдгэчихсэн!
Түүний нохой байхдаа би дуртай.
Би бол хамгийн аз жаргалтай нохой! ♥



# Ээж бол аугаа Их Багш гэж тэр надад хэлж өгсөн

Тэр биднийг авахаасаа өмнө таван нохойтой байсан юм билээ. Гэхдээ надад хамаагүй ээ. Түүний хайр бидэнд бүгдэд нь тэгш хүрэлцэнэ. Тэдэнтэй бүгдтэй нь, ялангуяа Goody хэмээх Ротвелиртэй би их дотноссон. Тэрээр маш их гэгээрсэн бөгөөд надад маш олон зүйлийг зааж сургасан юм. Бид учрахаасаа ч өмнө холбоотой байсан. Тэр надад Ээж бол аугаа Их Багш, тиймээс бид Түүнд хүндэтгэлтэй хандах хэрэгтэй гэж хэлсэн. Ээж маань амьтдад тун ч хайртай, Түүнтэй цуг байгаа нь үнэхээрийн аз завшаан гэдгийг бас ойлгуулж өгсөн. Тэр Ээжийг тун их санасан ч хараахан уулзаж амжаагүй байсан юм. Бусад дөрөв нь ч гэсэн "Түүнтэйгээ эргэн учрах өдрийг хоног тоолон хүлээж байсан".

Тэгээд дараагийн өглөө нь бид бүгдээрээ зэр чинээлэгнийх нь гадна цуглаад, Түүнтэй мэндлэхээр эгнэн зогсоцгоосон юм. Тэр санааг ойлгоод бидэнтэй уулзсандаа туйлын ихээр баярлаж, өөрийнхөө тавган дээрх амттай сайхан зуушаараа дайлж шагнасан билээ!

Түүнтэй анх учирсан тэдгээр өдөр, шөнийг хэзээ ч би мартахгүй. Яг л өчигдөрхөн юм шиг санагдаж байна! Бид "Ээж"-дээ үнэхээр их хайртай! Үүрд Түүнийгээ хайрлана.





Одоо, бидний хэдэн найзууд Түүний дэргэд, бусад ноходынхоо хамтаар сайхан амьдарч байна. Өдөр болгон тусгайлан зориулж бэлтгэсэн сайхан амттай, халуун хоол өгдөг. Бидэнд амин дэм, хоол унд, дулаахан ор, цэвэрхэн зөөлөн буйдан, зугаалах цэцэрлэг гээд бүх юм бий. Үүнээс сайхан амьдрал гэж юу байх вэ. Байгаа бүхний төлөө Бурханд талархъя.

Дэлхий дээрх бүх ноход бидэнтэй адил нөхцөлд амьдарч, хайр энэрэл, аз жаргалыг мэдрээсэй хэмээн би хүсч байна.








Тэр биднийг үргэлж хооллодог болохоор л!




Булангийн "дэлгүүр" орчихоод

ирж болох уу?!




Санаа зовох хэрэггүй,
хэдэн тоглоомон яс
аваад эргээд ирнэ ээ!








За, морьхон минь!
Намайг "Нуурсчин" гэв үү?
Тэр арай том л байгаа биз,
Гэхдээ би илүү хар!
Биеийн чинь хэмжээнээс айгаад байх юм алга!...
Ноцолдмоор байна уу ...
...гарах уу?



Одоо тэгвэл хэн нь өндөр байна даа?





Хэн нь хурдан мэрэхээ, үзэх үү, "цасан ширхэг" минь!



Түүнийг би цасан ширхэг, цагаан будаа,
цагаанаа...
гэж дууддаг ч бид найзууд.
Бид арьс өнгөөр ялгаварладаггүй!

Энэ залуугийн хувьд ч бас адилхан.
Би түүнийг "Томоо" гэдэг юм.
Тэр харин намайг "Хараа" гэдэг.
Гэлээ ч гэсэн хэн хэн нь
зүгээр ээ!





Амьдрал бол бидний хувьд диваажин.
Түүний хайр халамж, хамгаалал дунд
идээд л, унтаад л, тоглоод л байдаг.




Түүнтэй бид үүрд хамт үлдэх боломж хайрласанд Бурхан таньдаа гялайлаа. Энд хайраар өлгийдүүлж, халуун дулаан орчноор хүрээлүүлдэг. Бид бол эрх хонгор найз нөхдын сүрэг!

## Би сонсч байна.

Гэхдээ миний ярьснаас илүү сонирхолтой түүх чамд бий гэдэгт эргэлзэж л байна шүү.



*Тэр Унгарт байхдаа бас л гадаа хаягдаж, өдөр, шөнө, цас бороо, нар салхитайд ч үргэлж гинжтэй байсан юм. Өмнөх эзнээс нь түүнийг худалдаж авсны дараа (хүзүүн дэх чанга гавнаас болж үүссэн) шарх сорвийг гурван сар гаруй сувилан илааршуулж, дотор өвчнийг эмчилсэн. Одоо бол тэр зүв зүгээр. Тэр агуу хайрын сэтгэлтэй, үнэнч, эзнээ хамгаалдаг, бас эрх танхи.*

*Гэрт олуулаа байсаар байгаад сурчихсан тул гадаа ганцаараанг нь үлдээчихвэл гаслан уйлдаг.*

*Хоч нь: Морь, Том биет.*

*Урьд нь түүнтэй зүй бусаар харьцдаг*

*байснаас хүмүүст итгэл алдарсан ч одоо гэрийн сайн нохой болохын тулд хамаг чадлаараа хичээж байна.*

*Анх таарaлдахад хэдийгээр хэцүүхэн орчин нөхцөлд байсан ч намайг үнсэхээр ирж, нөхөрлөлийн тэмдэг болгон сарвуугаа өгч байсан сан. Ойролцоо нь нохойны ялгадас овоорчихсон үнэхээр бохир орчинд тэр байж билээ! Заваарч гүйцээд, хатсан талхны зах, хэмлээд хаячихсан талх төдий хоолтой, уух усны бараа ч үгүй, бетонон шалан дээр хэвтэж байсан. Нэлдээ хиртэж, тачирхан үстэй болчихсон түүнийг чанга, бариу хүзүүвчээр лав гинжилсэн учраас хүзүүнийх нь арьс шархалсан байв. Тиймээс малын эмч нар түүнийг эдгээх гэж багагүй хугацаанд асарч*



*сувилсан юм.*

*Тэр тэнд эзгүй байшин сахиж, тойрон шавах ялаа шавжинд бариулах шахан өдөр шөнийг өнгөрүүлж байв!*

*Анх манайд ирээд, танихгүй хүмүүс рүү хуцаж, дайрдаг байсан юм. Гэвч хэсэг хугацаанд сургасны эцэст одоо намуун зөөлөн, гэрийн хүн бүрт найрсаг ханддаг болсон. Гэвч хашир сэрэмжтэй том нохой учраас гомдоох санаа агуулаагүй ч түүний хэтийдсэн хүч тэнхээ таныг гэмтээж мэднэ!*

*Жаахан ширүүн дориуныг нь эс тооцвол одоо маш нөхөрсөг болсон бөгөөд өөрт нь хайраа хамгийн хачин жигтэйгээр илэрхийлэх Топпи хэмээх хочтой Hally-д маш тэвчээртэй ханддаг. (Нуруун дээр*

нь мордоод, хөөж гүйцээд, ахлагч гэдгээ танилах гэж хуцдаг).

Тэр үнэхээр сэтгэл татам, ялангуяа урьд өмнө нь хайр гэдгийг огт мэддэггүй байсан нохой гэхэд тун гайхалтай. Өөр хүмүүстэй гадуур гарсныхаа дараа үргэлж л гүйж ирээд “одоо болно” гэж хэлэхгүй л бол дэргэдээс минь салахгүй, аль болох ойрхон яваад л байна. Манайхан түүнийг ялгалгүй хооллож, арчлах хэдий ч хэн өөрийг нь илүү хайрлаж байгааг тун сайн мэднэ. Туйлаас үнэнч тэр амьтан ямар ч үед хайраа бусдаас нуухгүй.







Ингээд би төгс амьдралтай учрав!



Амьдрал
хар, цагаантай байдаг юм уу?



Үгүй дээ, амьдрал бол диваажин.



Амьдрал бол
НАРНЫ ГЭРЭЛ.







Амьдрал бол
БҮЖИГ
НААДАМ.











Тэр бол амьдралыг өөр болгодог гайхалтай эмэгтэй.





Эрх чөлөө

мандтугай.

Миний хүмүүн

төрөлхтөн мандтугай!







Нөхөрлөл

мандтугай.





Хайр бол халамж үзүүлэхийн нэр.



Хайр бас тэмүүлэл нэгтэй байхын нэр.



Клубт тавтай морил, хархан минь!






За, за!
Чи мундаг аа!



Тэг дээ! Чи үргэлж л тэгдэг шүү дээ, топпи.





"Би мордмоор байна!"

# ЧАМАЙГ ХАМГААЛЖ БАЙЯ♥



♥ Сайхан унт даа.

♥ Чамайг би хамгаалж байя,

♥ эрхэм Пух-пух минь.





Шинэ гэртээ би хайртай! (Анхны гэр.)

"Алив, залуус аа! Дасгалаа хийгээрэй!"







Энэ сүрэгт, бас сүргийн толгойлогчид би хайртай.
Хэн гэдгийг нь мэдэж байвал алгаа ташаарай!



Түүнд зөндөө
их "хоол"



бас асар их
гайхамшиг
бий.



... Мөн ярьсан үлгэрүүдийг нь





бид үүрд сонсоход ч бэлэн.



## Энэ бол миний гэр





Энд би хайранд умбаж,
халамжинд жаргадаг



Энд бид амьдралаа ч, хайраа ч хуваалцдаг!
Би Бурханд, бас Түүнд талархнам!



# Hally

*Zolo-гийн хөрш хоточ нохойн тухай хүүрнэе. Hally хэмээх нохой маань Унгарт гав гинжтэй зовж шаналж гүйцсэн байв. Түүний хэрийн бие хаатай өөр нэгэн нохой тэсгим хүйтний улмаас амьсгаа хураасан юм. Hally бол нэлээд чанга чийрэг, ширүүн дориун нохой боловч одоо хүмүүст найртай ханддаг болсон. Хаалга цонхоор төвөггүй үсрээд гарчихдаг, өндрөөс өндөрт дүүлэн харайчихдаг нохой доо. Өөрийгөө бусдаас дөвийлгөн, ихэмсэг бардам авирлах нь бий ч хүмүүст бол ямар ч гэм хоргүй. Хэдийгээр нэг дороос ирсэн ч Zolo-тойгоо үзэж тардаг. Тэр агуу хайрын сэтгэлтэй, үнэнч, эзнээ хамгаалдаг, бас эрх танхи.*

*Хоч нь: Орос Рулет (Орос нэр нь үсрэгч), Үсрэгч Жерки (тогтворгүй хөдөлгөөнтэй), Акробатич, Гимнастикч, Топпи (бусад нохдын дээр авирах дуртай), Баавгайхан (баавгайтай төстэй)*

*Hally гэр орноо эмх цэгцтэй байлгахыг л хичээдэг.*

*Хамгаалалтын нохой Zolo-г зуршил нь дийлж хүмүүс рүү довтлуузай гэсэндээ бусдыг түүнээс хамгаалдаг. Өөрийгөө золиод ч хамаагүй Zolo-г хүмүүст найрсаг хандахад сургахыг чармайх ажээ.*

*Hally бол хүмүүсийн үнэнч анд. Эзэнгүй орхисон фермийн хашаанд өдөр шөнөгүй, өвөл зунгүй гинжтэй байсан нохойноос тийм араншин гарна гэдэгт итгэмээргүй.*

*Тэр хүмүүний ертөнцийг хүндэтгэн дээдэлдэг. Хэн нэгэн түүнийг илэх юм бол гэдсээрээ дээш харах юм уу, эсвэл танд тэврүүлэхийн тулд урд савраа өгч өөрийнхөө "өхөөрдөм" аргыг хэрэглэнэ.*

*Тэр хайр нь дотроо хал нь гаднаа мэт Zolo-д ханддаг. Хэсэгхэн хугацааны "салалтын" дараа уулзахдаа (цаадахаасаа түрүүлж ирээд гэрийн гадаа арчилгаа цэвэрлэгээ хийлгэхдээ) Zolo-г бүхий л биеэрээ шахан налж хэвтэх дуртай.*



**Хоёр ч удаагийн хахир өвөл, халуун зуныг гадаа өнгөрүүлж, тэсч гарсан Унгарын шилдэг нохой бол Hally миний бие билээ.**



Эрх чөлөөтэй байх юутай сайхан.





Би үнэхээр муухай ааштай байсан. Хэрэв та тэсгим хүйтэн өвөл, шатам халуун зуныг гав гинжтэй өнгөрөөж, халуун дулаан сэтгэл, хайр халамжийг тийм урт хугацааны туршид үзээгүй бол муухай ааштай болохгүй гэж үү?

Гэвч би "нөхөрсөг" байж чадна аа.





Би нөхөрсөг байгаа биз

тийм үү?



**Хөлдүүс болсон биеийг минь мэдрээд,**

**харин миний өмнөх замыг та туулах гээд үз!**

Би одоо ч хамгаалагч





Намайг тэгж
сургасан юм
чинь!
(тоглосон юм)
Хэн тэгээд л
ийм ажлыг
хийж байх
вэ дээ...
Хав!



Би үнэндээ их нөхөрсөг.







Хараач дээ!
Би инээж байна?
(Одоо би үргэлж ийм байна.)

Намайг ч гэсэн "эрхлүүл л дээ"...



За, тэр!
Үүнийг л хэлээд байгаа юм шүү дээ!







Урьд нь намайг хэн ч ингэж хайрлаж байгаагүй.

Бас тэвэрч байгаагүй! Ай хөөрхий!








*Үлдэж буй амьдралынхаа туршид*

*би энэ газарчинг л дагана.*









**Гадаа**

*нарлаг*

*сайхан*



ZzZ

**Гэртээ**

*тавлаг*

*тухлаг!*

Би олон найзтай!





Зөндөө тоглоомтой,



бас зөндөө их хоолтой! Гоё шүү!





Мөд удахгүй



миний ээлж болно!

Үидүн жимсний модон доор суугаад
"Будда" болох болов уу?



(болох байх аа)

Эсвэл шалан
дээр хөлбөрч байгаад
гэгээрэлд хүрэх болов уу?



(Юутай ч би Бурханы оронд байна аа!!)





"Тэнд" юу байна?

Магадгүй би урьд төрөлдөө
баавгай байсан байх.



Би том
баавгай
шиг
санагдаж
байна.



Хэзээ ч юм
хаа нэгтээ модонд
авирч байсан
санагдах юм!

Авираад үздэг юм
билүү? "Одоо юу?"



Яагаад
болохгүй
гэж! Би
гимнастикч
юм чинь.



Акробат хийчих анд
нөхөр байна уу?



Чамайг Үсрэгч Жерки гэчихлээ, уучлаарай!



Тэгвэл...

хөлөө сэгсрээд

эвлэрчих үү?...

– "Болох л юм" –



Найз минь хэлээч дээ,





Би хамгийн

мундаг нь мөн үү!!

Биеэр жижиг гэж үү?

Тэр хамаагүй ээ!

# Хөршийнхөө нохойг хайрла



Хөршийнхөө нохойг хайрла











Ээжийн хийж өгсөн өвлийн шинэ цамц, оймсыг Bella өмсчээ. Бас шинэ хоолонд орсон (Веган хоол! Үнэхээр янзтай).

# ТӨГСГӨЛИЙН ОРОНД

*Энэ номонд нохой хэмээх ер бусын амьтны тухай хэсэг бусагхан зураглан толилуулав.*

*Ямар ч нохойны амьдрал болон зан төрхийн талаар бүхэл бүтэн том ном бичиж болно. Юутай ч нохой бол туйлын ариухан амьтан билээ.*

*Хорвоо ертөнцөд бидэнтэй цуг оршиж, ихийг тусган ойлгодог аливаа нохдын гайхалтай замналыг зурвасхан харуулж, уншигч танаа сэтгэлийн цэнгэл эдлүүлэхийг зорив.*

*Бодит ертөнцөд хамаг амьтан харилцан адилгүй хэлбэр дүрснээ хувилж, сонголтоо хийж байдгийг хэн бүр мэдээсэй. Ямар ч амьтан бидэнтэй адил. Тэд цаг хугацаандаа амьдрахаар, элдэв үйл, зүйлээр газар дэлхийн өнгийг баяжуулахаар мэндэлдэг. Тэд биднийг дагалдан хүндэтгэл болоод амгалан жаргалан, хайр энэрэл эдлэхээр найрсан ирдэг.*

*Бид энэхэн насандаа амьтны ертөнцийн аливаа нэгэн гишүүнтэй нөхөрлөн найрсах аваас өөрсдөө адислагдаж, аз шүүрч буй нь тэр юм шүү!*



**Их Багш тодорхой тус хүргэсэн дараах хүмүүст гүнээ талархаж байна:**

Кристал Во, Виктор Нго, Т.Жүнь, Томас Люкс, Стивен Андре, Данни Ву *(Зурагчин)*

Анние Юу, Надир Иен, Чиень Вэй Ба-Ли, Ким Чэнг, Жакие *(Загвар болон номын гадаад, дотоод загвар)*

Гари Лай, Надир Иен, Иүй Хүй - Чүнь, Ванг Бор Танг, София, Жакие *(График дизайн)*

Линн МакЖий, Жейн Чү, Вэнкинг Ли, Бекки Чень, Сүнь Ванг, Клэйр, Мүүн *(Хэвлэлийн эхийг хянасан)*

Д.Гүн-Үйлс
*(Монгол хэлнээ хөрвүүлсэн)*

Л.Билгүүнтөгс
*(Хянан тохиолдуулсан)*

*"...Ажил үйлсээрээ хайрыг түгээж байгаа бүхэнд"*

***~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай***



# Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

## *Хамаг төрөлтнийг энэрч нигүүлсэхүйн ютай ч зүйрлэшгүй үлгэр дууриалал*

Буй ертөнцийг бүрэн ойлгосон машид гэгээрсэн Гэгээнтнүүдийн хувьд энгэл ертөнцөөс хол, ууланд дияанчлан амьдрах нь санаа, зовнилоос ангид, нэгэн аз жаргал байдаг. Гэсэн хэдий ч Тэд хамаг төрөлтөнд туслан, үлгэр дууриал болох үүднээс энгэл ертөнцийн замналыг ямагт сонгодог юм. Иймийн учир заримдаа Тэдний амьдрал, гэгээлэг үг яриа, үйл хэргээс хормын төдийд тусыг хүртэн, суралцах хувь ерөөл бидэнд тохиодог билээ. Дараах түүх нь Их Багшийн нэгэн туслахын бичсэн үнэн түүх юм.

2005 оны есдүгээр сарын нэгэн өдөр Их Багш (Европын) нэгэн орны хөдөө нутгийн гахай зэрэг амьтны ферм рүү нисдэг тэргээр очсон юм. Гэвч тэндхийн байр байдал тааруухан, туйлын эмх замбараагүй, бохир газар байв. Орох хаалганы дэргэдэх харуулын байрны зэргэлдээ өмнө нь аж ахуйн хуучин тоног төхөөрөмжийн агуулах байсан бетонон ханан хашаатай өргөн бөгөөд хэсэгхэн тэгш талбай байлаа. Их Багш нисдэг тэрэгнээс буугаад, харуулын байрны урд талд хоёр метр хагасаас илүүгүй урттай гинжээр уягдсан хоёр жижигхэн нохой хэвтэж байхыг олж харсан юм.



Нохдын хөл хүрч чадах талбай нь дан тоос шороонд дарагдчихаад байсан ба нэг талд нь хуучин, хэмхэрхий нохойны үүр байв. Талбайн нөгөө тал нь нохойн ялгадсаар дүүрчихсэнийг харахад тэнд нохдыг олон сараар уясан нь илэрхий байв. Хөөрхий амьтдын урд тал дахь таллаж тайрсан бохир хуванцар саван дотор нь өмхий ус, хатсан талх байв. Тэдгээр европын үсэрхэг нохос туйлын хүнд нөхцөлд, хоол тэжээлээр дутмаг төдийгүй ялгадсан дээрээ хэвтэж байснаас болж бохирдож гүйцээд, ойртохын аргагүй үнэр танартай байв.

Тэрхүү бетонон талбайн эсрэг талд онгорхой үүр хэлбэртэй, нэг нэгнээ налаад нурах шахсан хоёр хананы урд талд немц овчаркны эрлийз гэмээр том, үслэг нохой байхыг Их Багш туслахуудтайгаа явж байгаад олж харсан юм. Бусад нохдын адилаар, тэр ч бас гурван метрээс илүүгүй урттай гинжээр гинжлүүлсэн байв. Гэхдээ энэ нохой нь бусдын адил байранд бус харин хоёр бетонон хананы дундах зайд хоргодож байсан бөгөөд тэрхүү зайн хоёр тал нь салхи, бороонд ив илхэн байлаа. Тоос шороонд дарагдаад, шалбааг туначихсан хонгилын дотор талд энэ нохойн эзэмшил талбай нь мөн л хог ялгадсаар дүүрчихсэн байлаа. Тэнд гурав дахь нохой нь ч байсан юм. Тэр талбайгаа цэвэрхэн байлгах гэсэндээ нэг буланд нь л бие засдаг байсан боловч гинж нь үргэлж газар чирэгдэж, ялгадсыг нь бүх газраар тараасны улмаас мөн л өөрийн өтгөн шингэн дээрээ хэвтэхээс өөр сонголт үлдээгүй юм.

Их Багш энэ дүр зурагт цочирдон эвгүйцэж, тэр даруй нохдын эзэн хэн болох талаар, яагаад ийм хүнлэг бус нөхцөлд нохдыг байлгаж байгааг асууж тодруул гэж захилаа. Хөөрхий амьтадыг өрөвдөн хайрласандаа Их Багш хамгийн түрүүнд том нохой руу ойртон очиход, өөд нь тэмүүлж, сониучирхан, баяртайгаар сүүлээ годгонуулан



Их Багш Zolo-той анх уулзах үед туслахуудын авсан бодит зураг

уггжээ. Их Багш дөхөж очоод илэхэд өнөөх нохой тэр даруй савраа найрсаг зөөлнөөр өгсөн юм. Бусдын харгис хэрцгийлэлийг амсаж үзсэний эцэст хайр энэрлийг нь хүртэж буй тэдгээр амьтдад Их Багш агуу нинжин сэтгэлээ үзүүлж, тэднийг өрөвдөн уйлж эхэлсэн юм. Тийнхүү Их Багш өөртөө байсан бүх хоол хүнсээ, цэвэр усны хамт нохдод хайрлажээ.

Тухайн үед ферм эзгүй байсан тул нохдын эзнийг тодруулах талаар асуух хүн олдоогүй юм. Иймэрхүү нөхцөл байдалтай учирна гэж Их Багш бодоогүй ба тэр л үед нохдын байр байдлыг сайжруулах ямар нэг зүйл хийхээр шийдэж, эдгээр өрөвдөлтэй амьтадтай хамт цагийг өнгөрүүлэхийн тулд бусад ажлаа хойшлуулсан билээ. Тийн Их Багш нэгэн туслахдаа олон төрлийн веган зайдас, хиам, яс, жигнэмэг, нохойны органик веган бүтээгдэхүүн болон зөндөө их амттай хоол авч ирэн нохдыг цадтал нь хооллохыг даалгасан юм. Эздэд нь нохдоо зүй зохистой асарч хандан, өдөрт ядаж нэг удаа гинжнээс нь суллаж, эзэмшил талбайгаасаа өөр газарт бие засаж, ялгадсан дээр нь хэвтдэггүй болгохыг хүссэн захиа бичиж үлдээхийг Их Багш туслахууддаа захижээ. Эзэн нь ноходдоо дургүй юм бол энд байлгасны оронд дулаахан байлгаж хайрлах гэр бүлийг олж өгч чадах нохойн асаргааны газар тэднийгээ өгөхийг хүссэн талаар захианд мөн дурджээ.

Тийнхүү Их Багшийн хүсэлтээр туслахууд дараа сард нь хэд хэдэн удаа очиж, нохдод хоол хүнс, уух ус өгсөн юм. Гэвч очих бүртээ тэд нохдыг асарч халамжлах үүрэгтэй хүнийг огт олж чадаагүй бөгөөд харуулын байшин үргэлж хоосон, цоожтой байдаг байсан. Туслахууд нохдыг хооллохоор сүүлчийн удаа очиход тухайн ферм дээр ажиллаж байсан нэгэн настай эмэгтэй дугуй унан хүрч ирсэн юм. Тэд нохдын эзний талаар асуухад, нэгэн фермийн эзнийд байдаг гэж хэлжээ. Их Багшийн бодож байсанчлан тэр эзэн нохдоо суллачихвал зэргэлдээх тосгонд очоод хэрэг төвөг тарина гэж цаг үргэлж гинжтэй нь байлгадаг талаар тэр эмэгтэй ярьжээ. Түүнчлэн нохдод ус болон хатсан талхнаас гадна үе үе мах өгдөг гэж хэлсэн ч туслахууд тийм ямар ч ул мөр хараагүй юм. Тэгээд тэр эмэгтэй нохдын амьдралыг дээшлүүлэх тухай Их Багшийн захиаг эзэнд нь дамжуулна гэж амласан юм.

Өдөр хоног ч ээлжлэн солигдож хэдэн сарын турш Их Багш нохдын тухай ярьж, эзэн нь түүний зөвлөгөөний дагуу тэжээвэр амьтдадаа илүү хүнлэг байдлаар хандаж байгаа гэдэгт найдвар тавьсаар л байсан юм. Өвөл болж хүйтэрч эхлэхэд, Их Багш туслахууддаа дахин ферм тийш очиж, нохдын байр байдал сайжран өөрчлөгдсөн эсэхийг шалгахын сацуу хоол хүнс аваачихыг даалгаад, нөхцөл байдал зохих хэмжээнд дээшлээгүй байвал, тэднийг эзнээс нь худалдаж ав гэж даалгасан юм.

Туслахууд ферм рүү очоод, нохдын амь амьдрал сайжраагүйгээр үл барам харин ч улам дордсоныг ойлгоод ихэд шаналан зовнисон юм! Урьд нь байсан гурван нохойноос том, жижиг хоёр нохой нь л үлдсэн байв. Нөгөө жижиг нохой нь өлсгөлөн, хүйтнээс болж нүд аньсан байлаа. Үлдсэн жижиг нохойны гинж нь орооцолдож, ердөө нэг метр л урт болчихсон байж. Тиймээс хүйтэн, хэмхэрхий нохойн байр, хоосон, эвдэрхий усны савандаа ч хүрч чадахааргүй болчихоод бүр урьд өмнөхөөсөө ч илүү туранхай, бохир заваан харагдаж байв. Том нохойн нөхцөл байдал ч мөн сайжраагүй байв. Нөгөө л салхилдаг, бетонон байгууламждаа хоргодсон хэвээр л байсан юм. Харамсалтай нь аадар борооны улмаас амьдарч байсан хонгил нь улам чийгтэй, бохирдож гүйцээд бас дэргэд нь осгож үхсэн нэгэн тоорой хэвтэн ажихуйяа нөгөө



Их багш Zolo-той анх уулзах үед туслахуудын авсан бодит зураг



Их Багш Hally-г өргөж авсны дараа

нохойг маань өлссөндөө амьсгаа хураачих вий гэсэндээ үлдээсэн бололтой. Гэсэн хэдий ч нохой цогцсонд хүрэхийн оронд нь Их Багшийн илгээсэн веган зайдсыг баяр хөөртэй идчихсэн юм.

Аз болоход туслахууд эзэнтэй нь уулзаж, нохдыг худалдаж авсан ба буцах замдаа тэд машинд гайхалтай дуулгавартай байсны дотор нэг бяцхан нохой нь бүр жолоочийн өвөр дээр тухлан хэвтсэн гээч. Дараа нь Их Багш нэг туслахаа дуудан, нохдын нөхцөл байдлыг асууж мэдээд, эцэстээ тэдгээр амьтад туслахуудын өвөр дээр нь толгойгоо тавин амарч, хүний хайрыг анх удаагаа мэдэрсэн явдалд ихэд уяран баярлаж хөөрсөндөө уйлсан юм.

Тэгээд Их Багш нохдыг тэр даруй орон нутгийн шилдэг малын эмчид хандан, бүрэн үзлэг хийлгэхээр болсон юм. Малын эмч амьтдыг үзэж, жижиг нохойноос цусны шинжилгээ авахад гадаа хүйтэнд өлсгөлөн байлгаснаас бие нь муудсаныг эс тооцвол өөр өвчин зовиургүй байсан юм. Тэднийг гэрт буцаж ирэхэд Их Багш туслахууддаа жижиг нохойн үсийг зөв тайрч, усанд оруулахыг даалгасан юм. Гэхдээ том нохой тийм ч азтай байсангүй. Түүний хүзүү хавиас хурц эхүүн үнэр үнэртэж байсныг эмчид үзүүлэхэд иртэй хутганаас өөрцгүй өргөн бөгөөд нимгэхэн хуванцар хүзүүвчнээс болж хүйтэнд хоолой нь зүсэгдчихсэнийг олж харжээ. Байнга зүүлттэй байдаг хүзүүвчнээс нь болоод шарх нь аних аргагүй байжээ. Гүн шархнаас нь урсаж гарсан шингэн нохойн арьсыг өмхийрүүлснийг малын эмч өвчин намдаагч өгч, мэс засал хийжээ.

Ингээд цагаа олж ирсэн Их Багшийн тусламжийн ачаар, мэс засал амжилттай болж, айхтар шарх нь эдгэсэн юм. Их Багшийн зааварчилгаагаар түүний "туслахууд" хоёр нохойд уураг, витаминаар баялаг эрүүл веган хоол өгч, өдөрт таван удаа салхинд гаргаж байгаа! Энэрэл нигүүлсэл, хайр халамжинд умбасан амьтад одоо цэвэрхэн, дулаахан орчинд зөөлөн хөнжил, дэрэн дээр амарч унтдаг болсон.



Их Багш Zolo-г өргөж авсны дараа

"Би дэлхийн сая сая нохдыг харж хандаж хүчрэхгүй ч гэсэн надтай учирсан, тусламж хэрэгтэй байгаа тэдгээр нохдыг асарч халамжилж, туслах ёстой мэт санагддаг." хэмээн Их Багш айлджээ.

Хараа хяналтгүй Европ нохдыг сэтгэл гарган асарч, халамжилснаараа Их Багш маань бид бүгдэд энэрэл нигүүлслийн эрхэм дээд, сэтгэл уярам үлгэр дууриаллыг үзүүлсэн билээ. Өөрийн цаг наргүй үргэлжлэх ажлын зэрэгцээгээр Тэрбээр гараа сунгах төдийд байгаа хамаг төрөлтнүүдэд туслах үйлсээ бүтээсээр яваа юм. Дотоод хайрын хүч маань сэрэх тэр цагт бид Түүний үлгэр дууриаллыг дагаж, манай дэлхий улам сайхан болохыг мэдэрч эхэлнэ.



## Амьтад төдийгүй хамаг төрөлтний амьдралын сайн сайхны төлөө...

### Эрүүл, тухтай нохойн сууц

Нигүүлсэнгүй сэтгэлт Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай амьтан төдийгүй хамаг төрөлтний амьдралыг сайжруулах арга замыг байнга эрэлхийлж явдаг юм. Түүний нягт нямбай зааврын дагуу хүний хамгийн сайн анд нөхөрт зориулсан дулаахан, тавлаг нохойн сууцыг зохион бүтээжээ. Салхи, бороонoос хамгаалах оффсет хаалга, бат бөх модоор хийсэн, хуванцар хучлага бүхий цэлгэр тавцантай, эрүүл ахуйд нийцсэн тавлаг дэвсгэр, зуны цагт агаарыг чөлөөтэй нэвтрүүлэх хөдөлгөөнт цонхтой юм байна. Тус сууцыг угсрах болон цэвэрлэхэд их хялбар байдаг.

Хэдий иим тансаг сууцтай нохойг ч ялгаагүй халуун хүйтэн, аль эсвэл аюул заналаас холхон шиг шөнийн цагаар гэртээ хонуулж байвал зэрлэг араатан болон хулгайчдын олз болгохгүй шүү дээ гэж Их Багш сануулж байна. Нохойн сууц нь өдрийн цагаар тоглож наадахад л зориулагдсан болохоор бусад үед тэд "эздийнхээ" гэрт байсан нь илүү дээр юм.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хаягаас аваарай: http://www.godsdirectcontact.org.tw/eng/news/163/index2.htm, Holistic Animal Care section)









### Аз жаргалтай нохдын — Тэнгэрийн хувцас болон дэвсгэр



Мөн л Их Багш Чин Хайн энэрэнгүй зааврын дагуу Аз жаргалтай нохойн тэнгэрийн хувцас болон дэвсгэрийн анхны цуврал бий болжээ. Төрөл бүрийн хэмжээтэй, олон төрлийн хийц загвартай юм байна. Нохойн хувцаснууд нь гоёмсог хийцтэй, мөн биеийн дулааныг нь хадгалахад тустай бөгөөд хүний үнэнч анд нөхдийг маань ганган дэгжин харагдуулж, хүйтэн цаг агаарт дулаан байх боломжийг олгодог ажээ.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хаягаас аваарай: http://www.godsdirectcontact.org.tw/eng/news/167/index2.htm, Holistic Animal Care section)



### Нохойн эрүүл, зохистой хоол

Их Багш Чин Хайн асралт зааврын дагуу эрүүл, байгалийн гаралтай, веган хоолыг хүний анд нөхөр болох нохдод зориулан гаргажээ. Тус бүтээгдэхүүн нь амьтны гаралтай биш бөгөөд хоол зүйчид тусгайлан сайтар боловсруулан гаргасан юм. Гол найрлагандаа шар буурцгийн цэвэр уураг, эрдэнэ шиш, овьёос болон бусад үр тариа агуулах ба энэхүү эрүүл, зохистой хүнс нь хоол боловсруулалт болон бодисын солилцоонд тустай байдаг. Мөн амны хөндийн эрүүл мэнд болон дархлалын тогтолцоог сайжруулж, гялалзсан өнгөлөг үстэй болгодог бөгөөд энергийн өндөр агууламжийг нь дурдах нь илүү биз ээ.



Хамгаас энэрэлт Их Багш Чин Хай нохдыг шинэхэн бэлтгэсэн хоолоор хооллох нь сайн бөгөөд үүнийг шинэ хоол хийх боломжгүй юм уу завгүй өдрөө өөр нэгэн сонголт болгон хийж болно гэж зөвлөдөг юм.
(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хаягаас аваарай: http://www.godsdirectcontact.org.tw/eng/news/175/index.htm).

# Миний Амьдрал дахь Нохоод

Нохдоос сэдэвлэн

Эмхэтгэн найруулсан:
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Зураглаачид:
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай, Кристал Во, Виктор Нго, Т.Жунь, Томас Люкс, Стивен Андре, Данни Ву

Хэвлэлийн дизайн:
Анние Юу, Надир Иен, Чиень Вэй Ба-Ли, Ким (Формоса), Жакие (Шиху)

График дизайн:
Гари Лай, Надир Иен, Иуй Хуй-Чунь, Ванг Бор Танг (Формоса), София, Жакие (Шиху)

Хэвлэлийн эхийг хянасан:
Линн МакЖий, Жейн Чу, Вэнкинг Ли (АНУ), Бекки Чень, Сунь Ванг, (Формоса)

Хэвлэсэн газар:
Love Ocean Creative International Company, Ltd.
B2 No. 3, Ally 30, Lane 78, 2nd section, Fu-Shin south road, Da An District, Taipei 10664, Taiwan.
R.O.C.
Утас: +886-2-8789-6317, 2706-5528
Факс: +886-2-2707-7727
www.loveoceancreative.com
И-мэйл: info@loveoceancreative.com

Зохиогчийн эрх:
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай© 2007
(Монгол хэл дээрх нэгтгэсэн хувилбар)
Анхны хэвлэл: 2011 оны 09 сар
ISBN=865-800-06371-2-6 (нимгэн хавтас)

Бух эрх хуулиар хамгаалагдсан.
Хэвлэгчээс урьдчилан зөвшөөрөл авсны дараа та энэ номын агуулгыг дахин хэвлэж болно.

*...Би "Миний Амьдрал дахь Нохoд" номыг уншаад... маш их баяр жаргалтай байсан ба бидэнд нэгэн нийтлэг хүсэл байдгийг үнэн хэрэгтээ ойлгож ухаарсан юм: Бидний анд нөхөд энхрийхэн амьтдын амь амьдрал газар дээр ч бай, далай доор ч бай, бид амьдралдаа хүсдэг шигээ тэднийг хайрлаж, хамгаалж, энхрийлэх учиртай юм байна.*

**~Хүндэт, Архиепископ, Диосдадо Таламаяан, Д.Д., Филиппин,**

*Өө, бялхсан олон бүх нохдыг аварч, хайрлах нэг сая Төгс Гэгээрсэн Их Багш байдаг болч! Үүний оронд бид дэлхий дахины хүмүүс Төгс Гэгээрсэн Их Багшийн билиг оюун, зөвлөгөөг сонсоосой гэж л найдаж болох юм.*

**~Эммигийн Шагналт мэдээний сэтгүүлч Жейн Велез-Мичел, АНУ**

*Нохoд болон хүмүүст нийтлэг зүйл байдаг юм, тэр нь бол бидний Сүнс үндсэндээ нэг билээ.*

~К. Чен АНУ-н Харвардын Их Сургуулийн гишүүн судлаач асан.

*Бид амьтан ахан дүүсээ Бурханы бэлэг гэж хүндэтгэх учиртай, тэдэнд баярлаад зогсохгүй, мөн тэднийг хайрлаж, хамгаалах ёстой юм.*

**~Хелмут Ницшке, кино найруулагч, Берлин, Герман**

*"Миний Амьдрал дахь Нохoд" номын зохиолч нь чамин гоё, хөгжөөнтэй үгсээрээ дамжуулан, бидэнд хүн, нохдын хоорондох харилцан үйлчлэл, үнэн хайр болоод сүнслэг харилцааг ойлгоход тусалж байна.*

**~Ту Пай, нэртэй малын эмч, Формоса (Тайвань)**











8 658000 637126